

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ НОМЫН САН

СОЁЛЫН ГАВЪЯАТ ЗҮТГЭЛТЭН МАГСАРЫН БАЯНЗУЛ - 85

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛ

УЛААНБААТАР ХОТ

2013

ӨМНӨХ ҮГ

Монгол улсад номын сангийн салбар үүсч хөгжсөний 92 жил, Үндэсний номын сан байгуулагдсаны 92 жилийн ой тохиож буй билэгт сайн өдөр, 11-р сарын 19-ний өдөр Үндэсний номын санд хэд хэдэн арга хэмжээ зохион байгуулагдлаа.

Үүний нэг нь номын сангийн салбарын анхны Соёлын Гавъяат зүтгэлтэн, ахмад номзүйч, номын санч Магсарын Баянзулын мэндэлсний 85 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний бага хурал юм.

Энэхүү хурал нь СГЗ, ахмад номын санч М.Баянзулын Монголын номын сангийн салбарт оруулсан хувь нэмрийг сурталчлан таниулах, харилцан туршлага солилцох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, онол практикийн мэдлэгийн уялдаа холбоог сайжруулах ач холбогдол бүхий сүүлийн жилүүдэд болоогүй томоохон хурал болсоноороо онцлогтой.

Тус хуралд тавигдсан илтгэлүүдийг товхимолоор хүргэж байна.

МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН МАГСАР ОВОГТОЙ БАЯНЗУЛ

/Мэндэлсний нь 85 насны ойд/

Эрдэм номын замд зорьсон хэн бүхний оюуныг гийгүүлж, урмыг сэргээж урагш тэмүүлэх мөрөөдлийг хөтлөгч, номын өглөгч ахмадууд бол хойч үеийнхний бахархан дууриах үлгэрлэгчид билээ. “Номын сангийн нэвтэрхий толь” хэмээн уншигч олондоо хүндлэгдсэн Монголын номын сангийн анхны Соёлын гавьяат зүтгэлтэн Магсарын Баянзул нь номын сан-номзүй судлаач, сурган хүмүүжүүлэгч бөгөөд хичээнгүй нөр их үйлсээрээ монголын соёл судлал, номын сангийн шинжлэх ухааны хөгжилд жинтэй хувь нэмрээ оруулсан хүн юм.

Магсар овогтой Баянзул нь 1926 онд одоогийн Ховд аймаг, Мянгад сумын 7-р баг эдүгээ Баянбулаг багийн Хацарын өтөг /бууц/ хэмээх газар малчин ард Магсарын 7-р хүү болон төржээ. Хүүхэд насаа эцэг эхийн гар дээр өсөж хүмүүжин, 1934 онд нутгийн бичиг үсэгтэй Б.Цогт-Очир хэмээх хүнд шавь орж бичиг үсэг, тооны ухаан заалгажээ. Дараа нь 1936 онд нутгийн анхны бага сургууль /Даашин хүүгийн пүүсэнд/ байгуулагдахад орж суралцан, улмаар Ховд аймгийн төвийн дунд сургуулийн 7-р анги төгссөн. 1939 оноос суманд хуулан бичээч, дараа нь Ховд аймгийн шүүхийн нарийн бичгийн дарга болж, улсад анх удаа албан ажил хийж эхэлсэн байна. Улаанбаатар хотод ирж Дотоод яаманд төлөөлөгч, нарийн бичгийн дарга зэрэг ажлыг 1950 оны 7-р сар хүртэл хийжээ.

1950 оны дундуур Улсын нийтийн номын санд хуулан бичээчээр орж Д.Жадамба, Д.Сурмаажав, Д.Цэрэнханд, Я.Дагвадорж нарын ахмад номын санчдыг дагалдан ном ажиллах, каталог зохион байгуулах, номын фонд, үйлчилгээний ажлын дэг журмыг судалж, суралцан ном ажиллагч, каталогч, улмаар фондын хэлтэс, үйлчлэх хэлтсийн эрхлэгчээр дэвшин ажиллаж байсан байна.

М.Баянзул нь 1953 онд Найдангийн Сэмжидмаатай ханилж, 3 хүүхэдтэй өнөр өтгөн айл болж, том охин Б.Цэцэгмаа нь багш, дараагийн охин Б.Туул нь зүрх судасны эмч, отгон хүү Б.Баярсайхан эдийн засагч мэргэжил эзэмшиж, улс эх орондоо ажил хөдөлмөр эрхэлж байна.

М.Баянзул нь 1956 онд 6-р сургуулийн 10-р ангийг оройгоор төгсөж, гадаадад суралцах уралдаант шалгалтаа амжилттай өгч, ЗХУ-ын Москва хотноо Соёлын дээд сургуулийн номын сангийн ангид элсэн суралцсан нь түүнийг номын сангийн салбартай салшгүй холбосон юм.

1961 онд сургуулиа төгсөж ирээд М.Баянзул нь Улсын төв номын сангийн орлогч захирлаар, дараа нь захирлаар, 1980-аад оноос Мэдээлэл-арга зүйн хэлтсийн дарга, ахлах арга зүйчээр ажиллаж байгаад 1992 онд гавъяаныхаа амралтад гарсан юм. Тэрээр 1956 онд Засгийн газрын хүндэт жуухаар, 1966 онд Хөдөлмөрийн хүндэт медаль, 1971 онд МУ-ын Соёлын тэргүүний ажилтан цол тэмдэгээр, 1988 онд ШУА-ийн хүндэт тэмдэг, дипломоор тус тус шагнагджээ.

Түүний хөдөлмөр бүтээлийг нь төр засгаас өндрөөр үнэлж, 1992 онд Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн хэмээх эрхэм алдрыг хүртээсэн бөгөөд монголын номын сангийн салбарын анхдагч гавьяат юм.

М.Баянзул нь монголын номын сан судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан номын сан судлаач-номзүйч юм

М.Баянзул нь номын сан судлалын шинжлэх ухааныг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, соёлын өв уламжлалыг хадгалан хамгаалах үйлсэд өөрийн мэдлэг чадвар, бүтээлч хөдөлмөрөө зориулсан бөгөөд тэрээр номын сан судлалаар арав гаруй сурах бичиг, 30 гаруй номзүйн бүтээл, 200 гаруй өгүүлэл бичиж, 20 гаруй номыг редакторласан юм. Эдгээр бүтээлийг манай улсын өнцөг булан бүрт ажиллаж байгаа бүх номын санчид уншиж ашигласан гэж баттай хэлж болно.

М.Баянзулын 1962 онд бичсэн *“Номын сангийн арга ажиллагааны анхны мэдэгдэхүүн: Дүрэм, заавар, маягт, загварууд”*, 1968 онд бичсэн *“Номын фонд түүнийг хамгаалахуй”* эдгээр бүтээлүүд нь номын сангийн арга ажиллагааны чиглэлээр гарсан Монголын номын сан судлалын анхны дорвитой бүтээлүүд юм.

М.Баянзул нь төгсөж ирээд өөрийн сурч мэдсэн, судалж тогтоосноо гадаад, дотоодын мэргэжил нэгт нөхөд, шавь нартайгаа хамтран бодит ажил болгож байсан юм. 1962 онд М.Баянзул нь *З.Н.Амбарцумянын “Номын сангийн ангилал”*-ыг К.Н.Михайлов, Д.Сурмаажав, Б.Цэдэндорж нартай орчуулж, хэвлэсэн ба 1972, 1983, 1985 онуудад өөрийн шавь Ш.Базар, Н.Цагаач нарын хамт хүүхдийн номын сангийн *“Номын сан-Номзүйн ангилал”* номыг гаргасан нь номын сангийн арга ажиллагааг

шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулахад үнэтэй хувь нэмрээ оруулсан юм. Мөн тэрээр 1964 онд *Хурлат В.В. "Номын сангийн хэвлэл тодорхойлох гарын авлага"*, 1965 онд *Жамбаа Л. "Номын санчдад тусламж"*, 1966 онд *Данзан Д. "Лавлагаа номзүй"* зэрэг номын сангийн мэргэжлийн номыг редакторласан байна.

М.Баянзул нь олон арван номзүйн бүтээл гаргасан юм. Анхных нь *"1921-1955 онд монгол хэлэнд орчуулсан гадаад уран зохиолын номзүйн бүртгэл"* бүтээл нь 1957 онд хэвлэгдсэн бөгөөд *"Монголын уран зохиолын номзүйн тойм"* хэмээх 8 дэвтэр бүтээл нь монголын үндэсний номзүй судлалд томоохон байр эзэлсэн төдийгүй лавлагаа номзүйн чухал хэрэглэгдэхүүн гарын авлага болж байна.

Түүнчлэн "МХЗЭ-ийн номзүй 1921-1984", "Нийгэм-улс төрийн номзүй" (1986), "1980-1984 онд хэвлэгдсэн монгол номын бүртгэл", "ШУА-аас хэвлүүлсэн ном хэвлэлийн номзүйн бүртгэл" (1987) зэрэг мэдээлэл-номзүйн олон арван бүтээлийг нэрлэж болно. М.Баянзулын эдгээр бүтээлүүд нь өнөөдөр бүх төрлийн номын сан, номын санчид, эрдэмтэн судлаачид, уншигч залуусын лавлагаа-номзүйн гол хэрэглэгдэхүүн болохын зэрэгцээ мэргэжилтэн бидний өдөр тутмын гарын авлага болсоор байна. Өнөөдөр Үндэсний номын сан гэхэд мэдээлэл лавлагааны 30 %-ийг М.Баянзулын бүтээлийг ашиглан өгч байна.

Энэ бүхнээс дүгнэхэд М.Баянзул нь монголд номын сан судлалын үндэс суурийг тавьсаны зэрэгцээ орчин үеийн номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номзүй судлалыг хөгжүүлэх, уламжлалт өв соёлыг судлах, сурталчлах, нийтийн уншлагыг дэлгэрүүлэхэд үлэмж үүрэг гүйцэтгэсэн юм.

М.Баянзул нь сурган хүмүүжүүлэгч –багш, арга зүйч–зөвлөгч байсан юм

1960-аад оны эхээр аймаг, орон нутгийн номын сангууд хуримтлуулсан ном хэвлэлээ нийтийн хүртээл болгох талаар зохиодог ажил хомс, каталог, картын сан байхгүй, номын сангийн ажлыг зохион байгуулах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байсан юм.

1960 оны МАХН-ын Төв хорооны Улсын төрийн товчооны 126-р тогтоол, 1962 оны Сайд нарын Зөвлөлийн 388-р тогтоолд номын сангийн ажлыг сайжруулахыг онцгойлон зааж, номын санг аргазүйн талаар удирдан зохион байгуулах эрх үүргийг Улсын нийтийн номын санд даалгасан байлаа. Дээрх тогтоолыг биелүүлэх зорилгоор 1962-1965 онуудад 300-аад хүнийг курсээр сургаж,

үндэсний боловсон хүчин бэлтгэх, давтан сургах ажлыг М.Баянзул удирдан мэргэжил нэгт нөхдийн хамт амжилттай хэрэгжүүлсэн юм.

Мөн бүх аймгуудын сум, САА, техникум, дунд сургуульд номын сан шинээр байгуулахаар идэвхийлж, орон нутагт богино хугацааны сургалт, арга зүйн зөвлөгөөг биечлэн өгч ажилласны үр дүнд ном хэвлэлээ ангилах, каталог, картын санг зохион байгуулах, номын сангийн үйлчилгээг иргэдэд хүргэх боломж нээгдсэн юм.

М.Баянзул болон ахмад номын санчдын нөр их хөдөлмөрийн үр дүнд 1960-1970-аад онуудад номын сангийн тогтолцоо бүрэлдэн бий болж, манай улс номын сангийн үндэсний боловсон хүчнээр бэхэжсэн билээ.

М.Баянзул нь МЗЭ-ийн гишүүн, шүүмж судлаач, нийтлэлч байсан юм

М.Баянзул нь номын сан судлал, утга зохиолын шүүмж судлалаар 1956-1992 онуудад 200 гаруй өгүүллүүдийг сонин, сэтгүүлд нийтэлж, номын сан, ном хэвлэлийг олон нийтэд сурталчлах ажилд онцгой анхаарч байсан юм. Тэрээр “Ганжуур, Данжуурын учир”, “Соёлын өвийг хайрлая”, “Номын сан өнөөгийн шаардлага”, “Сумын номын сан-хөдөөгийн соёлын чухал голомт”, “Номын сангаас хүүхэдтэй ажиллах нь”, “Орчин үеийн шаардлага-номын сан” зэрэг өгүүллүүд нь номын сангийн өмнө тулгамддаг бэрхшээлүүд, номын санд тавигдах шаардлага, орон нутгийн номын сангуудын үйл ажиллагааг сайжруулах зэрэг олон чухал асуудлуудыг тусгасан нь өдгөө ч үнэ цэнээ алдаагүй байна.

М.Баянзул нь 1950-аад онд “Их хүч”, “Эрхэм бэлэг”, “Зочид” зэрэг шүлэг, “Алтай хязгаарын авьяаслаг дуучин”, “Баталов гуайн шавь” найруулал, тэмдэглэл, “Сүүлийн үеийн туужийн тухай тэмдэглэл”, “Номын хурим”, “Шастиныхан”, “Анхны шүлэглэлээс роман хүртэл”, “Манай он дарааллын хуудсууд” зэрэг судалгааны томоохон өгүүллүүд хэвлүүлжээ. Мөн Д.Содномдорж, С.Дашдэндэв, Н.Банзрагч, Л.Түдэв, Д.Даржаа, С.Удвал, Ш.Нацагдорж нарын зохиол бүтээлийн тухай болон гадаадын зохиолч В.Шекспир, М.Горький, Майн Рид нарын зохиол бүтээлийн тухай бичсэн өгүүллүүдийг нэрлэж болно.

Тэрчлэн эх орны дайны үеийн тухай “Сайн үйлсийн алдар мөнх”, “Газар газрын үлгэрүүд” гэдэг ном, зөвлөлтийн утга зохиол судлаач эрдэмтэн В.Пархоменкогийн “Зөвлөлтийн утга зохиол судлалын уламжлал, шинэчлэл” гэсэн

томоохон бүтээлүүдийг орчуулж хэвлүүлсэн байна. Мөн “Детише революции”, “Библиографические обзор”, “Государственная публичная библиотека МНР”, “Некоторые вопросы деятельности национальной библиотеки МНР” зэрэг 10 шахам өгүүллийг зөвлөлтийн хэвлэлүүдэд хэвлүүлжээ. Энэ бүхнээс харахад М.Баянзул нь номын сангийн хөгжилд цагийн салхинд үл балрах үнэ цэнэтэй хувь нэмэр оруулсан мэргэжилтэн байгаад зогсохгүй нэр хүндтэй орчуулагч, шүүмж судлаач байжээ.

М.Баянзул нь Орос, Узбек, Унгар, Польш зэрэг орнуудад болсон номын сангуудын Олон улсын хуралд эх орноо төлөөлж, монголын номын сангийн хөгжлийг дэлхий дахинд сурталчлах үйлсэд үнэтэй хувь нэмрээ оруулсан юм.

М.Баянзул нь ухамсарт бүхий л амьдралаа монголын соёл, түүний дотор номын сангийн үйл ажиллагааг хөгжүүлэхэд зориулсан бөгөөд Монголын номын сангийн түүхэнд тод мөрөө үлдээсэн энэ эрхэм хүний эрдэм мэдлэг, хөдөлмөр зүтгэл, бүтээл туурвил нь монгол улсын үе үеийн номын санчдыг галт бамбар мэт газарчлан дагуулж, номын сан, соёл судлалд үнэ цэнээ алдахгүй оршсоор байх болно.

М.Баянзул ба номын сангийн салбарын аргазүйн

ажлын үүсэл, хөгжил

Би Магсарын Баянзултай 30 гаруй жил хамт ажиллаж, эхлээд миний дарга, сүүлийн 10 гаруй жил би дарга нь болж байлаа. Би энэ хүнээс ихээхэн зүйлийг сурч мэдсэн миний өдий зэрэгтэй яваа нь энэ хүний ач тус гэхээс өөр аргагүй юм. Шинэ ба хуучин монгол бичгээр маш сайхан бичнэ. Хүнд тусархуу, уурлана гэж байхгүй, олон нийтийн ажилд идэвхтэй оролцоно. Тэр үеийн МАХН-ын Төв хорооны улс төрийн товчооны 1960 оны 4-р сарын 20-ны өдрийн 126-р тогтоолоор тус орны нийт номын санг аргазүйн талаар удирдан зохион байгуулах зорилгоор И.В.Сталины нэрэмжит улсын нийтийн номын сангийн дэргэд эрдэм шинжилгээ арга зүйн хэлтсийг байгуулсан нь бүх төрлийн номын сангуудыг аргазүйн нэгэн удирдлага, сургалт явуулах боломжийг олгосон юм. Хэлтсийг анх байгуулахад эрхлэгчээр орлогч захирал Г.Ренчинсамбуу, ахлах судлагч зааварлагчаар Л.Жамбаа, номзүйчээр Д.Бүрэндалай нарын 5 оронтойгоор ажиллаж байсан юм.

1961 оны 10-р сараас орлогч захирал М.Баянзул, хэлтсийн эрхлэгч Л.Жамбаа, ахлах судлагч-зааварлагч Ш.Базар, судлагч зааварлагч Г.Пүрэвдорж, ахлах номзүйч Д.Бүрэндалай ажиллаж байв. Магсарын Баянзул 1961 онд ЗХУ-ын Москва хотод (Молотовын нэрэмжит байсан) Соёлын дээд сургуулийн номын сангийн ангийг төгсөж ирээд Улсын төв номын сангийн орлогч захирлаар томилогдон ажиллаж байхдаа Монгол улсын номын санг хөгжүүлэх талаар цаашид ямар ажлууд хийвэл зүйтэй болох талаар идэвхи зүтгэл гарган, уйгагүй ажиллаж эхэлжээ. Энэ үед /1960–аад оны эхээр / зөвхөн аймаг, хотууд номын сантай зарим томоохон суурин газрууд, сум, сангийн аж ахуйд номын сангүй, аймгийн номын сангууд нь хуримтлуулсан ном хэвлэлээ нийтийн хүртээл болгох талаар зохиодог ажил нь хомс байлаа.

Тэнд каталог, картын сан байтугай төсөв төлөвлөгөө ч байхгүй, номын сангийн ажлыг зохион байгуулах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байсан юм. БНМАУ-ын Соёлын яам нь эдгээр байдалд дүгнэлт хийж, номын сангийн талаар бодлого боловсруулан Улсын төв номын сан голлох үүрэг гүйцэтгүүлэхээр онцлон заасан байна.

Тухайлбал, 1960 оны 4-р сард МАХН-ын төв хорооны улс төрийн товчооны 126-р тогтоол, 1962 оны 7-р сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 388-р тогтоол гарч номын сангийн ажлыг сайжруулах, ялангуяа хүн ам суурьшсан газар бүхэнд номын сан байгуулж, түүнийг материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлэх, сургуулиудад номын сан, уншлагын газар байгуулах зэрэг чухал заалтууд орсон байв. Энэ ажлыг гүйцэтгэхэд улсын хэмжээний бүх номын санг аргазүйн талаар удирдан зохион байгуулах эрх үүргийг Улсын нийтийн номын санд нэр заан цохож даалгасан байлаа.

Тийм хариуцлагатай үүргийг биелүүлэхийн тулд юуны өмнө номын сангийн урт богино хугацааны семинар, курс зохион байгуулж орон нутагт очоод ажиллаж чадахуйц мэргэжлийн хүн хэрэгтэй тул 1962 оноос эхлэн 6 сарын курсыг 1962, 1963, 1964, 1965 онуудад 4 удаа явуулж 300-аад хүнийг сургаж түүнд М.Баянзул, Л.Жадамба, Д.Сүндэв, Ш.Базар, Д.Сурмаажав, Вера Хурлат нарын зэрэг мэргэжлийн багш нар хичээл зааж байжээ.

Дараа нь бүх аймгуудад мэргэжлийн хүмүүс хуваарилагдан гарч аймгуудын бүх сум, САА, дунд сургууль, техникумуудад номын сан шинээр байгуулж ажиллуулах болжээ. Дараагийн жилүүдэд аймгууд өөр өөрсдийн аймгуудад богино хугацаагаар /2-3 долоо хоногоор, 1 сарын гэх мэт / курс семинар байгуулж сургаж байжээ. Энэ үед гарын авлага болох ном, сурах бичиг хэрэгтэй болсон тул М.Баянзул, Д.Сурмаажав, К.Н.Михайлов, Б.Цэдэндорж нар хамтран монголын номын сангуудад зориулан “Номын сангийн аравтын ангилал” хэмээх сурах бичиг орчуулан, зохион гаргаж хэвлүүлсэн нь бүх номоо номын сангийн дүрэмт ажиллагаанд оруулан каталог, картын санг бий болгох, үйлчилгээг зохих журмын дагуу явуулахад чухал үүрэг гүйцэтгэж, номын сан дүрэм ёсоор ажиллах бололцоотой болжээ.

“Номын сангийн арга ажиллагааны анхны мэдэгдэхүүн” гэдэг номыг М.Баянзул зөвлөлтийн номын сангийн мэргэжилтэн дэд эрдэмтэн К.Н.Михайловтой хамтран бичиж 1962 онд хэвлүүлсэн байна. Энэхүү гарын авлага номонд номын сангийн дүрэм, заавар, маягт загваруудаас гадна номын сангийн арга ажиллагааны анхан шатны бүхий л шаардлагатай лавлахууд, тус бүрийг гарчиглан оруулсан байна. Номын сангийн фондын тоо бүртгэлээс эхлээд зохиогчийн тэмдгийг тодорхойлж, ном ангилах, ном уншигчдыг бүртгэн авах, ном хэвлэлийг гэрээр болоод уншлагын танхимд олгох техник арга ажиллагаа, номын сангуудын ном хоорондын солилцооны

ажлын арга техникийг хүртэл номын сангийн өдөр тутмын ажлын бүхий л талыг хамруулсан ажиллагаа бүрд 148 аргачлалыг энэ номд багтаажээ.

М.Баянзул МАХН-ын улс төрийн товчооны 126-р тогтоол, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 388-р тогтоолыг аймгуудын намын хороо, АДХГ, захиргааны хурлаар хэлэлцүүлж, сум нэгдэл, сангийн аж ахуй, сургуулийн номын сангуудыг шинээр байгуулах, ажиллаж буй номын сангуудын ном хэвлэлийг номын сангийн арга ажиллагаанд оруулах, номын санчдыг урт, богино хугацааны курсээр бэлтгэхэд ихээхэн үнэт хувь нэмэр оруулсан хүний нэг юм. М.Баянзул, Л.Жамбаа бид нар аймгуудыг хуваан авч газар дээр нь заавар зөвлөгөө өгч тусалдаг байлаа. Одоогийн Монгол улсын үндэсний номын сангийн 1968 оны төлөвлөгөөнд нэг аймгийн нэг сум нэгдлийн номын санг одоогийнхоор бол загвар номын сан болгохоор оруулсан юм.

Баянзул гуай намайг нэг өдөр өрөөндөө ороод ир гэдэг юм. Чи өөрийн аймаг, өөрийнхөө суманд загвар номын сан байгуулж чадах уу гэсэн юм. Би чадна гэлээ. Данзан захирал дээр намайг дагуулж ороод дээрхи надад хэлдэгээ хэлэхэд дуртайяа зөвшөөрч, тэр үеийн 10 сая төгрөгийн үнэтэй ном, ширээ, сандал каталогийн шүүгээ, бичгийн машин, хувцасны өлгүүрийг 51 маркын машинд ачаад аймгийн намын хороо, захиргааны хурлаар оруулж, Халзан суманд өгөхөөр шийдвэрлүүлж билээ. Энэ номын сангийн эрхлэгч нь 50 гаруй насны Лувсаншарав гэдэг нилээн сэргэлэн хүн байв. Тэр “Би яаж номын сангийн мэргэжилтэй болох вэ? Таныг дагаад явж болох уу” гэлээ. Би зөвшөөрөөд аваад явлаа. Нөгөө хүнээ Баянзул захиралд танилцуулахад “Би сарын дотор сургана” гэдэг юм. Лувсаншарав номын сангийн анхны мэдэгдэхүүнтэй болж, Дорнод аймгийн гэрээний модны үйлдвэрийн 2 айлын байшинг сумандаа авчирч, номын сангаа өөрөө бариад, гурван удаа улсын тэргүүний номын сангаар шалгарч, диплом мөнгөн шагнал авч байсан юм. Түүний гарын шавь Лувсаншарав, “Сүхбаатарын одон”, “Хөдөлмөрийн гавьяаны улаан туг”, “Алтан гадас” одонгоор тус тус шагнуулж байлаа.

М.Баянзулын гарын шавь Лувсаншарав Монголын номын санчдын дотроос ганцаараа “Сүхбаатарын одон”-гоор шагнуулсан байдаг юм.

Би гэхэд 18 аймагт 1-3 удаа 300 гаруй сумын номын сангийн ажлыг шалгаж, заавар зөвлөгөө өгч аргазүйн туслалцаа үзүүлсэн байдаг юм. Баянзул захирал түүнээс олон аймаг, сумын номын санд очиж, дээрхи ажлыг гүйцэтгэсэн гэж боддог.

Бас бүсчилсэн номын санчдын 30-45 хоногийн сургалтыг явуулдаг байлаа. Ингэхдээ сургалт явуулсан аймгийн нэг сумын номын сангийн бүх номыг ангилж,

дансалж, карт бичиж, төрөл, үсэг дарааллын каталогийг зохион байгуулж, номыг нь тавиурт төрөл үсэг дарааллаар байрлуулж, уншигчийн карт нээж, сумын намын үүр хороо захиргаанд хүлээлгэж өгдөг байв. Тухайлбал: Өмнөговийн Номгон, Сэврэй, Дорнодын Хөлөнбуйр, Булган, Сүхбаатарын Асгат, Баяндэлгэр, Сэлэнгийн Зүүнхараа, Ховдын Мянгад, Баян-Өлгийн Алтанцөгц, Хэнтийн Батноров, Говь-Алтайн Бигэр, Хөвсгөлийн Аршаант, Баянхонгорын Өлзийт зэрэг сумдыг нэрлэхэд таатай байна.

Нэг өдөр намайг орлогч захирал байхад халамцуухан орж ирээд “Намайг аймаг сумдад томилолтоор явуулахгүй байна. Би бүх аймаг сумдын номын санд аргазүйн туслалцаа үзүүлсэн хүн шүү дээ” гэлээ. Одоо бодоход түүнээс илүү байж мэдэх юм. М.Баянзул нарын санаачлагаар ховор номын үзэсгэлэнгийн танхимыг 1976 оны 8-р сарын 4-нд байгуулсан нь одоо музей болж өргөжин, гадаад дотоодын зочин төлөөлөгчид, иргэдийн сонирхон үзэх дуртай газрын нэг болжээ. Номын санчдыг мэргэжлийн онол, аргазүйн материалаар хангадаг “Номын санч” сэтгүүлийг 1975 оноос эхлэн гаргасан нь эдүгээ 38 дахь жилдээ гарч Монголын номын санчид, багш, оюутан, мэргэжилтний өдөр тутмын гарын авлага болж байна. Энэ сэтгүүлийг Баянзул нөхдийн хамт санаачлан гаргаж, өөрөө идэвхтэн бичигч нь болж байлаа.

Монголын соёлын гавьяат зүтгэлтэн М.Баянзулын Монгол улсын бүх төрлийн номын санд үзүүлсэн аргазүйн туслалцааг биеэр болон сурах бичиг, гарын авлага, зөвлөмж, сонин, сэтгүүл, телевиз радиогоор үзүүлснийг товчхон дурьдахад ийм байна. Таны 85 насны ойг хамт ажиллагчид, шавь, үр хүүхдүүд чинь тэмдэглэж байгааг мөнх тэнгэрийн орноос харж байна гэдэгт итгэж байна.

XX ЗУУНЫ МОНГОЛ НОМЗҮЙН СУДАЛГАА

Ном хэвлэлийг номын сан, уншлагын газраар дамжуулан нийт хэрэглэгчдэд хүргэх ажилд “Номзүй” томоохон үүрэгтэй бөгөөд XX зуунаас соёлын нэгэн шинэ нэр томъёо болон гарч, шинэ салбар ухаан хөгжих, үндэсний уламжлалт номзүйг шинжлэх ухааны үүднээс эргэн судлах үндэс суурийг тавьж өгсөн юм.

XX зууны Монгол номзүйн хөгжлийг үндсэн 5 зүйлээр тодорхойлж болохоор байна:

1. Төрийн бодлогод хэрхэн тусгагдсан
2. Улсын номзүйн бүртгэл гарын авлагыг бүтээсэн байдал, түүнд хийсэн судалгаа
3. Мэдээлэл номзүйн нөөцийн бүрдүүлэлт, Лавлагаа номзүйн үйлчилгээ
4. Номзүйн салбарын хөгжилд эрдэмтэн судлаачдын оруулсан хувь нэмэр, дүгнэлт
5. Орон нутгийн номзүйн хөгжил

1. Төрийн бодлогод хэрхэн тусгагдсан

1921 оны 11-р сарын 19-нд улсын бага хурлын шийдвэрээр Судар бичгийн хүрээлэнгийн дэргэд одоогийн МУҮНС байгуулагдаж¹ эхэлснээр шинжлэх ухааны үндэстэй номзүйн бүртгэлийг төлөвшүүлэхэд ихээхэн анхаарч багагүй ажил зохиож иржээ. Энэ ажил 1960 оноос улам эрчимжиж, онол, аргазүйн үндэслэл улам боловсронгуй болж ирсэн юм.

Номзүйг хөгжүүлэх талаар:

“...Хэвлэлийн бүтээгдэхүүнийг хөдөлмөрчдөд тайлбарлан таниулахад зориулсан номзүйн (библиография) лавлах бичгийг гаргах үүргийг Улсын төв номын санд хариуцуулсугай”;

“...1913 оноос 1960 он хүртэл хэвлэгдсэн монгол номын бүртгэл, XVI зуунаас одоо хүртэл монголын тухай гадаадын хэвлэлд гарсан ном өгүүллийн бүртгэлийг

¹ Монгол улсын Ардын засгийн газрын 1921 оны 11-р сарын 9-ний өдрийн 24-р хурлын тогтоолын 3-р зүйл. “Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд УБ., 1954. 188-189-р тал.

1963 онд ШУА, Улсын хэвлийн хэрэг эрхлэх хорооноос эрхлэн хэвлүүлж гаргах ажлыг зохиосугай”²;

“...Номын сангийн мэргэжлийн болон номзүйн холбогдолтой сурах бичиг, гарын авлагыг 1975–1980 онд багтаан гаргасугай”³;

Мөн ШУА-ийн тэргүүлэгчид, намын төв хорооны товчооны хавсарсан тогтоолоор ...Монгол номын бүртгэлийг 3 жилд, тогтмол хэвлэлийн өгүүллийг 2 жил тутам гаргах⁴ хэмээн заасан нь ХХ зууны номзүйн хөгжлийг дэмжсэн төрийн бодлого байлаа.

2. Улсын номзүйн бүртгэл, гарын авлагыг бүтээсэн байдал, түүнд хийсэн судалгаа

Үүний үр дүнд Сонин сэтгүүлийн өгүүллийн он дараалсан бичиг-25, номын номзүйн лавлах-14, бусад салбар номзүйн гарын авлага-77 хэвлэгдэн гарсан байна.


Дээрх бүтээлүүдэд судалгаа хийж, энд тэнд холилдон буруу ангид орсон зүйлийг зөв ангид түүвэрлэн нэмэх, хасах г.м. илүү дутууг магадлан судалж үзвэл 1930-аад оноос 1990 он хүртэл ойролцоогоор **18000** орчим нэр төрлийн ном товхимол хэвлэн нийтлэгдсэн мэдээллийн нөөц байна. Эдгээрийн дийлэнх хувийг нийгэм улс төрийн, түүний дотор Марксизм-Ленинизмийн ном зохиол зонхилж, хамгийн бага хувийг шашны ном эзэлж байна, өөрөөр хэлбэл, 1900-1990 он хүртэл шашны талаар 30 гаруйхан ном хэвлэгдсэн нь бүгд шашингүйн үзлийн ном зохиол байсан юм.

² МАХН-ын ТХ-ны Улс Төрийн Товчооны 1960 оны 4-р сарын 20-ны 126-р, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1962 оны 7-р


сарын 27-ны өдрийн 388-р, мөн

³ СнЗ-ийн 1974 оны 9-р сарын 6-ны 342-р тогтоол

⁴ “Улсын номын сангийн тухай” 1968 оны 6-р сарын 4-ний өдрийн 15/1-31-р тогтоол




Ном хэвлэлийн төрөл График №1



50 жилээр авч үзвэл График №2

XX зуунд монгол улсад хэвлэгдсэн тогтмол хэвлэлийн өгүүллийн нийтлэлд судалгаа хийж үзвэл 70 шахам мянган өгүүлэл нийтлэгджээ. Үүнийг төрөл зүйлээр харуулбал:



Үүнээс үзэхэд нийт өгүүллийн 58 хувийг нийгмийн салбарын, хамгийн бага буюу 0 хувийг шашны талаарх бүтээл эзэлж байна. Зөвхөн нам, эвсэл холбоод, олон нийтийн байгууллагын холбоотой 15293 өгүүлэл нийтлэгдсэн байна. Дээрх байдлаас үзэхэд монголын хүн амын 166 хүнд 1 ном, 42,8 хүн тутамд 1 нийтлэл оногдож байгаа юм.

3. Мэдээлэл номзүйн нөөцийн бүрдүүлэлт, Лавлагаа номзүйн үйлчилгээ

Сүүлийн он жилүүдэд цахим хэлбэрийн техник тоног төхөөрөмж, аппарат хэрэгслээр номын санг хангах үйл ажиллагаа эрчимтэй явагдаж байна. Тэр ч бүү хэл Номын сангийн үйл ажиллагааг хөнгөвчилөх, лавлагаа мэдээллийн үйл ажиллагаанд зориулсан **Тусгай программ** зохиогдсоноор өдгөө “Номын сангийн автоматжуулалт”-ын тухай ойлголт Монголын төдийгүй, дэлхий нийтийн тогтолцоот хөгжлийн хэлбэрийг олж байна гэж дүгнэж болно.

Хэдий тийм ч Монгол улсын хэмжээнд төрөлжүүлсэн мэдээллийн сангийн нөөц бага байна. Өнөөдрийн байдлаар уламжлалт картын сан, цахим мэдээллийн нөөц эрэл хийх түвшинд хүрээгүй байгаа, өөрөөр хэлбэл, EBSCO /Өрнө дахины Нийгмийн ухааны сэтгүүлийн өгүүллийн цахим мэдээллийн сан/ мэт Монголын хэвлэл мэдээллийг цахим өгөгдөлд зориудаар оруулж нийтийн хүртээл болгох асуудал дутагдалтай гэсэн үг.

Номын сангийн үндсэн үүрэг –хэрэглэгчдийг хэрэгцээтэй мэдээллээр ханган үйлчлэх явдал билээ. Тиймээс номын сан нь зөвхөн “ном өгч уншуулах объект” байсаар байвал, тийм номын сантай дэлхийн аль ч улс орны номын сан “Мэдээллийн төв”-ийн статусын хүрээнд орж чадахгүй үлдэнэ.

Манай номын сангуудад олон сайхан төсөл, арга хэмжээ, хандив тусламж 1990-ээд оноос тасралтгүй явагдаж буйг хүн бүхэн мэднэ. Харин нэг бодлогын доор “**нэг эрхэм зорилго**”-той байх асуудал чухал болохыг өнгөрсөн он жилүүдийн туршлага харуулж байна. Өөрөөр хэлбэл, олон янзын программ /CDS/ISIS, L-Soft, LIB-4U, Alice/, олон ангилал /НСНА, ДАА/, ном бүрдүүлэлт, мэдээллийн сангийн нөөц г.м. асуудлыг авч хэлэлцэхдээ үлдэц багатай, тарамдуу маягтай хийсэн байна. Тиймээс МУҮНС-ийн нэгдсэн бодлогоор цаашид хамтран ажиллабал зүйтэй санагдана.

4. Номзүйн салбарын хөгжилд эрдэмтэн судлаачдын оруулсан хувь нэмэр, дүгнэлт

Аль ч улс орны судлаачид “номзүйн” мэдээллийн чухал болохыг судалгааны ажлын хүнд хэцүү, урт удаан хугацаанд дам дашрамд тэмдэглэсээр иржээ.

Б.Ринчен

“...Ашгүй буриад монголын барламал номын гарчгийн талаар баримт олдохгүй байтал нэгэн сайхан барын гарчгийг олов... үүнд Буриад монголд 31 бархан лавтай ажиллаж байсан байна” хэмээн тэмдэглэсэн бол

МУИС-ийн багш **Д.Чойжилсүрэн** “Буриад номын таван гарчиг” нэртэй номзүйг 1956 онд анх гаргаж, өдгөө Р.Отгонбаатар үргэлжлүүлэн модон барын гарчигзүйг Японд хэвлүүлснийг тэмдэглэж байна.

Ц.Дамдинсүрэн

Эрдэмтэн Ц.Дамдинсүрэн 1960-аад оноос монголч эрдэмтдийн хуралд “Цэг, Цэглэл хэрэглэхийн учир” нэртэй илтгэл хэлэлцүүлж, цуврал өгүүлэл нийтлүүлсэн нь номзүйн бичилтийн чухал элементүүд байсан юм, мөн түүнчилэн 13-р зуунд монгол эрдэмтэн Биразинаширын гэрийн номын сангийн тухай дурдсан нь нилээд эрт үед холбогдох номзүйн талаар сануулсан тэмдэглэл хэмээн үзэж болно.

Л. Түдэв

“...Номыг номынх нь хувьд судлахаас гадна номзүй судлалын арга барилаар танин мэдэхийг эрхэмлэсэн бүтээлүүдийн талаар үнэлж бичсэн зүйл “Дал сонин”-д нийтлэгджээ”⁵.

М.Баянзул

“...Цаашид Монголын номзүй судлалыг баяжуулж улам дэлгэрэнгүй материалыг хамрахын тулд гадаад орнууд, ялангуяа монгол судлал хөгжиж буй Орос, Хятад, Япон, АНУ, Герман, Англи, Энэтхэг, Финлянд, Канад, Франц, Австрали зэрэг олон улс орны баялаг номын сангууд, тэдгээр орны монголч эрдэмтэдтэй холбоо тогтоож мэдээлэл-номзүйн баялаг материалыг авч монгол орны болон монгол туургатны түүх соёлын талаар төрөлжүүлэн мэдээлэх нь улам дорвитой бүтээл болох билээ”⁶ хэмээн тэмдэглэсэн.

⁵ “Дал” сонин. 1999. №7

⁶ Баянзул М /Соёлын гааяат зйтгэлтэн, ахмад номзүйч/ Ж.Цэзэнгийн битээлийн тухай дигнэлт тодорхойлолт. 1993 оны 6-р сарын 28-ны өдөр. СУСХ-ийн 1993 оны тайлан

Г.Ринченсамбуу

“...Номзүйн ухааны үүднээс “Уламжлалт монгол номын хөгжил”-ийг онол, түүх, зохион байгуулалт, аргазүйн үүднээс судлах, сонирхох хэн бүхэнд зам мөрийг гийгүүлэх ач холбогдолтой юм”⁷ хэмээн тодорхойлсон байна.

Л. Хүрэлбаатар

“...Монгол ном, монгол номзүйн уламжлал бол Шар мөрний эргээс Адриатикийн тэнгис хүртэлх Ази Европын өргөн уудам нутаг дэвсгэртэй, өнө холын цаг хугацаатай холбогдох ойлголт” билээ. Номзүйн тухай европ боловсролыг монгол, дорно дахины, тэр дундаа буддын шашны соёл боловсрол гүнзгий нэвтэрсэн орны номзүйн соёлын уламжлалт хөрсөн дээр шилжүүлэн суулгаж, түүн дээрээсээ номзүйн шинжлэх ухааны өрнө дорнын харьцаа холбогдол, өвөрмөц, нийтлэгийн асуудлыг шинжлэн тогтоосон байна⁸.

Ш. Чоймаа

“...Аливаа үндэстний үе үеийн ухаантан, мэргэдийн бодлын хур, оюуны охь нь үсэг бичиг хэмээх дохио бэлгэ төгс дүрс тэмдгийн ид шидэт хүч чадлаар судар шастир, ном зохиол болон хувирч, зуун зууныг сундлан зул шиг гийгүүлсээр, зулайд дээдлэгдэх шүтээн болдог жамтай ажээ. Номын тухай ном, ном судалдаг ухаан гэж бас байх агаад түүний нэг нь “Монгол номзүйн онол түүхийн зарим асуудал” хэмээх энэ ном яах аргагүй мөн ажээ. Энэхүү судалгааны бүтээлийг орчуулга хөрвүүлэггүйгээр хилийн чандад суудаг монгол угсаатан үзэж унших боломжтой боллоо⁹ хэмээн тэмдэглэсэн байна.

С.Цэцэгмаа

“...Шинжлэх ухаан мэдээллийн үсрэнгүй хөгжлийн эрин үед номын санч, номзүйчдийг мэдээллийн мэргэжилтний түвшинд бэлтгэх, боловсон хүчинг эх хэлээрх бүтээл, түүний дотор суралцах бичиг, гарын авлагаар хангах асуудал нэн чухал болж байна. Иймд Ж.Цэзэнгийн “Салбар номзүй” чухал гарын авлага болно¹⁰ хэмээн тэмдэглэжээ.

⁷ Соёл урлаг судлалын хйрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлын архив фондод бий

⁸ Цэзэн Ж. Монгол номзүйн уламжлал. /Өмнөтгөл/. УБ., 2002.- 7-р тал.

⁹ Цэзэн Ж. Монгол номзүйн уламжлал. /Талархлын үе/. УБ., 2002.- 9-р тал.

¹⁰ Цэзэн. Ж. Салбар номзүй /Удиртгал иг. УБ., 2002.- 5-р тал.

Б. Тунгалаг

“Монгол судар номын гарчигзүйн бүтэц тогтолцоо” –хэмээх энэхүү нэгэн сэдэвт бүтээлийн нэрийн дор монголын номзүйн хөгжлийн зүй тогтол бүрэн хамрагдсан”¹¹ гэж үзэж байна.

5. Орон нутгийн номзүйн хөгжил

Орон нутагт 1950-аад оноос хэвлэлийн газрыг байгуулахын зэрэгцээ, “уншлагын тэнхим” нэртэй газрыг аймгийн үзэл суртлын хэлтсийн дэргэд байгуулснаас хойш 70 гаруй жил болжээ. Энэ хугацаанд аймаг орон нутгийн хэвлэлийн хөгжлийг баримжаалин төсөөлөх нилээд зүйл хийгдсэнийг хэвлэх үйлдвэрийн түүхэн хөгжлийн баримтаас харж болно.

Гагцхүү энэ хугацаанд номын сангууд номзүйн бүртгэл мэдээллийг хэрхэн хийж мэдээллэсэн талаар авч үзэхэд тун бага зүйл харагдана. Дархан, Ховд, Өвөрхөнгөй, Дорнод, Дундговь, Хэнтий зэрэг аймгуудад магистрын дипломын түвшинд хийсэн хэд хэдэн сайн ажил байгааг эс тооцвол бусад, мэдээлэл номзүйтэй холбоотой ажлууд нийтэд мэдээлэгдээгүй байна. Ялангуяа орон нутгийн мэдээллийн нөөцийг стандартын түвшинд хийж цахим болон цаасан хэлбэрээр ашиглах асуудал чухал байна.

Дүгнэлт

- Монгол улсын үндэсний номзүйн хөгжлийн хөтөлбөр боловсруулж ажиллах шаардлагатай
- ЮНЕСКО-с эрхлэн гаргадаг олон улсын номзүйд Монгол номзүйн мэдээллийг оруулах талаар чухалчилах
- Монгол номзүйн бүртгэлжүүлэлтийг бүрэн болгох төсөл боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжих, хамтран ажиллах






¹¹ Ж.Цэзэнгийн Sc.D-ийн урьдчилсан хамгаалалтанд хэлсэн үг 2010. - СУИС-ийн ЭЗХ.

МУСГЗ Магсарын БАЯНЗУЛЫН номын сан судлалд оруулсан хувь нэмэр

“Нэгэн дусал бэх мянга мянган хүний оюуныг сэргээж, мэдлэг ухаарлыг хайрлана” хэмээх мэргэн үг буй. М.Баянзулын үзэгнээс дуссан хэд хэдэн дуслын/ном зүй судлал, утга зохиолын шүүмж судлал гм./ нэг нь номын сан судлалд тодоос тод мөрөө үлдээжээ. М.Баянзул Номын сан судлалын талаар арав гаруй сурах бичиг бичиж, 20 гаруй номонд редактор хийж, 200 гаруй өгүүлэл бичсэн байна.

Сүүлийн үед Номын сан судлалын шинжлэх ухаан нь номын сангийн фонд, номын сангийн каталог, номын сангийн үйлчилгээ, номын сангийн удирдлага, номын сангийн түүх, номын сангийн техник хэрэгсэл гэсэн голлох зургаан зүйлийг авч үзэх болсон.

1974 онд Ш.Базар, Л.Жамба нартай хамтран гаргасан “Номын сангийн судлал” гэсэн ном хэвлүүлсэн байна. Уг номонд номын сан судлалыг:

-  Номын сангийн ажлын зохион байгуулалт,
-  Номын сангийн хөмрөг
-  Номын сангийн ангилал
-  Уншигчидтай ажиллах
-  Номын сангаас зохиох СОНА гм. хэд хэдэн хэсэгт хувааж үзсэн байдаг.

Эдгээр заалтад тулгуурлан түүний зохиол бүтээлүүдийг тус бүр заалтуудад хуваарилан номын сан судлалд оруулсан хувь нэмрийг тодруулахыг оролдлоо.

Номын сангийн ажлын зохион байгуулалт-ын талаар:

Баянзул М. Номын сангийн арга ажиллагааны анхны мэдэгдэхүүн: Дүрэм, заавар, маягт, загварууд.- УБ., 1962.- 72 х.: Уг номыг СГЗ Н.Цагаач “148 зүйлт, аргачилсан заалт агуулсан энэхүү номд аливаа номын санд заавал хөтлөгддөг бүртгэл тооцоо, баримт бичгүүдийн загварыг хавсаргасан нь бүр ч их ашиг тустай, үзүүлэн таниулах чадвартай зүйл байлаа” хэмээн үнэлжээ. Мөн “Энэ ном бол

Монголын номын сан судлалын анхны дорвитой бүтээл болж үлдсэн билээ” гэсэн байна.

Номын санч нар номын сангийн нэр томъёо, арга ажиллагааны тухай анхан шатны мэдэгдэхүүнтэй болсны дараагаар бас нэгэн зүйл дутагдаж байгааг мэдэрчээ. Энэ нь олон уншигчийн гар дамжсаар элэгдэж, хуучирч, муудсан номыг яах вэ гэсэн асуудал байв. Энэ асуудлыг шийдэж өгсөн ном бол:

Жамбаа Л. Номын сангийн ном сэлбэлт, засалт, тоноглол төхөөрөмж / Ред. М.Баянзул.- УБ., 1962. гэсэн ном байлаа. М.Баянзул уг номын редактороор ажиллажээ. Тухайн үед/тавь, жараад оны үе/ хэвлэгдэн гардаг байсан номууд хавтас үдээс муутай хэвлэгддэг, тэр тусмаа шинэ тутам байгуулагдсан Шинжлэх ухааны академийн хэвлэл нооргор хөх өнгөтэй нимгэн хавтастайгаараа, амархан урагддагаараа нэрд гарч “Хөх даалимбан дээлт” гэсэн нэрийг аваад байсан үе юм. Уг ном номын сангуудад ном сэлбэн засах газар байх ёстой хэмээх чухал асуудлыг хөндсөн байсан нь нэн чухал ач холбогдолтой байв.

1960 онд МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоо 126 дугаар тогтоол гаргаж номын сангийн ажлыг сайжруулах арга хэмжээний тухай заалт өгч түүнийг хэрэгжүүлэх талаар БНМАУ-ын Сайд нарын зөвлөл 1962 онд 388 тоот тогтоол гаргасны дараагаар Хурлат В.В. Номын сангийн хэвлэл тодорхойлох гарын авлага / Ред. М.Баянзул.- УБ., 1964. хэмээх номыг Улсын нийтийн номын сангаас эрхлэн хэвлүүлжээ. Уг ном нь 1959 оны “Хэвлэлийн зохиолд каталог үйлдэх товч заавар”-ын дэлгэрүүлэн, сайжруулсан хоёр дахь хэвлэл юм. Ингэснээр энэхүү гарын авлага нь зааварчилгаанаас урагш ахиж арга зүйн чиглэлтэй, системчилсэн гарын авлага болсон юм.

Эдгээрээс гадна:

Жамбаа Л. Номын санчдад тусламж / Ред. М.Баянзул.- УБ., 1965.

Данзан Д. Лавлагаа номзүй / Ред. М.Баянзул.- УБ., 1966. гэсэн номуудын редактороор ажиллаж нэр бүхий сонин сэтгүүлүүдэд өгүүлэл, нийтлэл хэвлүүлжээ¹.

¹ Баянзул М. Номын сангийн номын тооллогыг яаж хийх вэ? // Соёл. - 1969. - №3.

Баянзул М. Номын сангийн талаар өгөх зөвлөмж // Номын санчдад тусламж. - 1980. - №4. - Х.1-8.

Баянзул М. Номын сангийн тооллогыг яаж хийх вэ? // Номын санч. - 1997. - №1-2. - Х.7-15.

Баянзул М. Диссертаци, авторефератын фондтой ажиллах эрдэм шинжилгээний номын сангийн ажил // Номын санч. - 1987. - №1-2. - Х.41-44.

Баянзул М. Сургуулийн номын сангийн каталог, картын сан // Хүүхдийн хүмүүжил. - 1973. - №1.

Номын сангийн хөмрөг: сэдвийн хүрээнд:

Баянзул М. Номын фонд түүнийг хамгаалахуй / Ред. Д.Хорлоо.- УБ., 1968.- 122х. номондоо номын сан фондоо хэрхэн бүрдүүлэх, түүний бүртгэл тооцоог хэрхэн хөтлөх, ном алдагдах, үрэгдэхээс хэрхэн хамгаалах тухай нарийн тодорхой зааж, баримтад тулгуурлан бичжээ.

Баянзул М., Базар Ш., Жамба Л. Номын сангийн судлал / Ред. С.Лувсанням.- УБ., 1974.- 166х. хамтарсан ном хэвлүүлсэн байна. Уг ном нь номын санчдын сонирхсон асуултад хариулт өгсөн чухал ач холбогдолтой ном болж чадсан юм.

Мөн Үнэн, Утга зохиол урлаг, Соёл зэрэг сонингуудад энэ сэдэвтэй холбоотой өгүүлэл нийтлэл² хэвлүүлжээ.

Номын сангийн ангилал-ын чиглэлээр:

Монголд 1930-аад оны үеэс Аравтын ангилал, 1950 оноос З.Н.Амбарцумянын “Номын сангийн ангилал”-ыг хэрэглэж эхэлсэн байна. 1962 онд М.Баянзул З.Н.Амбарцумянын “Номын сангийн ангилал”-ыг К.Н.Михайлов, Д.Сурмаажав, Б.Цэдэндорж нарын хамтаар Орос хэлнээс бүрэн эхээр нь орчуулж хэвлүүлсэн байна.

Гэвч удалгүй З.Н.Амбарцумянын “Номын сангийн ангилал” сэдэв агуулгын хувьд хуучирсан тул шинжлэх ухааны үндэслэлтэй шинэ ангилал хэрэглэх шаардлага гарсан байна. Ингээд 1985 онд ЗХУ-д шинээр гарсан “Библиотечно-библиографической классификации” ББК ангиллыг Ш.Базартай хамтран өөрийн орны нөхцөлд зориулан номын сангийн болон шинжлэх ухааны олон салбарын эрдэмтэн мэргэдийн тусламжтайгаар боловсруулан “Номын сан-Номзүйн ангилал” хэмээх ном гаргажээ. Энэхүү ангиллын номыг гаргахаасаа өмнө 1972 онд Ш.Базартай хамтран “Номын сангийн ангилал”, 1983 онд Н.Цагаачтай хамтран хүүхдийн номын сангуудад зориулсан “Номын сан-Номзүйн ангилал”-ын ном хэвлүүлжээ.

Мөн “Номын санч”, “Номын санчдад тусламж” гэх мэт сэтгүүлүүдэд ангилалтай холбоотой нийтлэлүүд хэвлүүлжээ³.

² Баянзул М. Номын сангийн номыг хайрлан хамгаалууштай // Үнэн. - 1954. - №243.

Баянзул М. Соёлын өвийг хайрлан хамгаалъя // Үнэн. - 1963. - №189.

Баянзул М. Номын сан-өнөөгийн шаардлага // Утга зохиол, урлаг. - 1964. - №33.

Баянзул М. Номын сангийн хөмрөг // Монгол улс. - 1969. - №11.

Баянзул М. Номын ашиглалт номын сангаас шалтгаална // Үнэн. - 1986. - №310.

Баянзул М. Номын сан - өнөөгийн шаардлага // Үнэн. - 1989. - №287.

Баянзул М. Фондын хамгаалалт // Номын санч. - 1984. - №3. - Х.21-31.

Уншигчидтай ажиллах ажлын хүрээнд:

Баянзул М. Номын сангийн ажлын туршлагаас.- УБ., 1962.- 53 х. Бие даасан ном Цэндсүрэн О. Хүүхдийн уншлагыг удирдах нь / Ред. М.Баянзул.- УБ., 1968.

Сонин сэтгүүлүүдэд өгүүлэл, нийтлэл хэвлүүлжээ⁴.

Номын сангаас зохиох СОНА

Баянзул М. Номын сан бол хүмүүсийн соёлжих төв байх ёстой // Номын санч.- 1988.- №3.- Х.7-9.

Өнөөдөр дэлхийн дахинаа тухайн уран бүтээлч, зохиолчийн зохиол бүтээлүүд шинээр гарч буй хичнээн зохиол бүтээлд иш татагдаж байна, түүгээр тухайн уран бүтээлч, зохиолчийг үнэлэх болжээ. М.Баянзулын ном бүтээл, нийтлэлүүд өнөөдөр Монголын бүх төрлийн номын сангийн номын санчид, оюутан залуус, судлаачдын өдөр тутмын гарын авлага болж, иш татагдан хэрэглэгдсээр байгаа нь ямархан үнэ цэнэтэй болохыг илэрхийлж буй хэрэг юм. Түүний зохиол бүтээлүүд 20 гаруй сурах бичиг, ном, 100 шахам эрдмийн ажилд иш татагдсан байна/албан бус тооцоогоор/.

Түүний зохиол бүтээлүүдээс иш татагдсан байдлын тухай товч дурдваас:

М.Баянзулын туурвисан номын сан судлалтай холбоотой бүтээлүүд эрдэмтэн, судлаачдын бүтүүлүүдэд иш татагдсан байдал:

1. Цагаач Н. Монголын үндэсний номын сан/Түүхэн бичлэг/.- УБ., 2001- 224хууд.:

Уг номыг туурвихдаа:

- Баянзул М., Михайлов К.Н. “Номын сангийн арга ажиллагааны анхны мэдэгдэхүүн”.- УБ., 1962.- 72хууд.
- Баянзул М. “Номын фонд, түүнийг хамгаалахуй”.- УБ., 1968.- 122хууд.

³ Баянзул М., Базар Ш. Нийтийн номын сангийн шинэ ангилал // Номын санчдад тусламж. - 1982.- №3.- Х.1-7.

Баянзул М. Номын сан-номзүйн ангиллыг хэрхэн хэрэглэх тухай аргачлал // Номын санч. - 1987.- №1-2.- Х.4-18.

⁴ Баянзул М. Зөвлөлтийн ном сурталчлах ажлыг өргөн зохиоё // Соёлын ажилтанд тусламж. - 1967.- №2.

Баянзул М. Ном, хэвлэл, уншигч // Үнэн. - 1970.- №258.

Баянзул М. Номын сангийн ажлыг үйлдвэрлэлтэй холбоё // Үнэн. - 1970.- №272.

Баянзул М. Номын сангаас хүүхэдтэй ажиллах нь // Хүүхдийн хүмүүжил. - 1972.- №3.

Баянзул М. Зөвлөлтийнхөн бидэнд тусалсан юм // Номын санчдад тусламж. - 1976.- №2-3.- Х.32-34.

Баянзул М. Сайн ажилтай номын сан // Номын санч. - 1987.- №3.- Х.4-6.

- Баянзул М., Базар Ш. “Номын сан-Номзүйн ангилал”.- УБ., 1985.- 268 хууд.
- Жамбаа Л. “Номын сангийн ном сэлбэн засалт, тоноглол төхөөрөмж”.- УБ., 1976.- 1962хууд.
- Жамбаа Л., Намсрай Б., Сүндэв “Номын санчдад тусламж”.- УБ., 1965.- 178хууд.

Дээр дурдагдсан 1962 оны Сайд нарын зөвлөлийн 388 дугаар тогтоол гарсан нь Монгол улсад номын сангийн бүхэл бүтэн тогтолцоо буй болгоход гол үүрэг гүйцэтгэсэн маш тодорхой заалт бүхий чухал баримт бичиг бөгөөд Монгол улсын соёлын амьдралд бодит үр нөлөөгөө өгсөн ажил хэрэгч шийдвэр байсан учир асар богино хугацаанд улс орон даяар олон арван номын сан, уншлагын газрууд байгуулагджээ.

Уг тогтоолын 14 дүгээр заалтад “аймаг, хот, сум, нэгдлийн номын санд тохирох нэг загварын байшингийн зураг төслийг 1963 онд багтаан гаргаж өгөх” тухай дурдсан байна. БНМАУ-ын Соёлын яамны сайдын 1965 оны 2-р сарын 27-ны өдрийн 19 тоот тушаалаар аймаг, хотын номын сангийн 100 мянган номын багтаамжтай, уншлагын танхим, үйлчилгээний бусад өрөө тасалгаа бүхий нэг загварын барилгын зургийг БНБАУ-ын барилгын мэргэжилтнээр хийлгэх гэрээний дагуу уг зургийн баримт боловсруулахыг улсын номын сангийн мэргэжилтэн М.Баянзулд даалгажээ. Тэр үед номын сангийн дээд мэргэжил эзэмшсэн хүн гэвэл М.Баянзул, Г.Ринченсамбуу нар байжээ.

М.Баянзулыг УТНС-ийн захирлаар ажиллаж байх үед БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл “Номын сангийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол гаргасан байна. Энэ тогтоол гарснаар номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгож Монголын номын сангуудын тогтолцоог улам бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Монгол улсын Соёлын гавъяат зүтгэлтэн Н.Цагаач М.Баянзулыг номын сангийн даргаар томилогдсон үйл явдлыг “...дээд боловсролтой мэргэжлийн номын санч ийнхүү төв номын санг удирдах болсон нь уул байгууллагын ажлыг мэргэжлийн өндөр түвшинд хүргэхэд чухал ач холбогдолтой байсан юм...” хэмээн дүгнэжээ.

1960 оны МАХН-ын Улс төрийн товчооны 126-р тогтоол, 1962 оны Сайд нарын зөвлөлийн 388-р тогтоол гаргахад М.Баянзул голлох үүрэг гүйцэтгэсэн юм.

Дээрх тогтоолууд номын сангийн ажлыг боловсронгуй болгох, номын сангийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, сурах бичиг, гарын авлагаар хангах, номын

сангийн материаллаг баазыг бэхжүүлэх заалтууд орсон байна. Энэхүү хариуцлагатай үүргийг биелүүлэхийн тулд 1962-1965 онуудад номын санчийн 6 сарын курс, аймгуудын бүсчилсэн 30-45 хоногийн сургалтыг М.Баянзул гардан зохион байгуулж иржээ.

Номын сан судлалын өөр нэг судлагдахуун бол номын сангийн байр сууц, мэргэжлийн боловсон хүчний асуудал юм. М.Баянзул Монголын номын сангийн анхны дээд мэргэжилтэй боловсон хүчний хувьд энэ бүх асуудлыг шийдэж өгснөөрөө Монголын номын сан судлалын үндэс суурийг тавьсан юм.

**Магсарын Баянзулын бүтээлүүд номын санчдын
сургалтын хэрэглэгдэхүүн болох нь**

“Хүмүүний сэтгэлийг хөдөлгөж эс чадваас
Хөнгөн бийрийг хөшиж юу хийнэ” хэмээн их Инжинаш айлдсан байдаг.

Тийм лүгээ адил Магсарын Баянзулын бүтээл туурвил нь мэргэжил нэгт нөхдийнхөө ажил үйлсийн голч шугам, үлгэр жишээ, мэдлэг туршлага болж байдаг билээ.

М.Баянзул нь монголын номын сангийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан сурган хүмүүжүүлэгч төдийгүй түүний бүтээж туурвисан олон ном хэвлэл нь номын сангийн сургалт, судалгаа, лавлагаа номзүйн гол гарын авлага болон хэрэглэгдсээр байгаа юм.

Энэхүү илтгэл маань Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Магсарын Баянзулын:

- Монголын номын сангийн салбарын үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд оруулсан хувь нэмэр;
- Түүний бүтээн туурвисан номын сангийн мэргэжлийн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлүүд нь өнөөг хүртэл сургалт, судалгааны гол хэрэглэгдэхүүн гарын авлага болох нь;

гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.

1. Монголын номын сангийн салбарын үндэсний мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэхэд оруулсан хувь нэмэр

Магсарын Баянзул нь 1950 оны дундуур И.В.Сталины нэрэмжит Улсын нийтийн номын санд хуучин монгол номыг гараар хуулан бичээчээр орж тухайн үеийн ахмад номын санч Д.Жадамба, Д.Сурмаажав, Я.Дагвадорж нарыг дагалдан ном ажиллах, каталог зохион байгуулах, номын фонд, үйлчилгээний ажлыг суралцаж байжээ.

1956 онд гадаад улсад явж суралцах уралдаант шалгалтанд тэнцэн ЗХУ-ын Москва хотод /Молотовын нэрэмжит байсан/ Соёлын дээд сургуулийн номын сангийн ангид орж суралцан 1961 онд төгсөж ирээд Улсын төв номын сангийн орлогч захирлаар томилогдож байжээ.

Тэрээр Монгол улсынхаа номын санг хөгжүүлэх талаар цаашид ямар ажлууд хийвэл зүйтэй болох талаар эргэцүүлж, уйгагүй ажиллаж эхэлсэн байна. Энэ үед /1960-аад оны эхээр/ зарим томоохон суурин газар, сум, сангийн аж ахуйнуудад номын сан хараахан байгуулагдаж амжаагүй, зөвхөн аймаг, хотуудад төвлөрсөн номын сантай тэдгээр нь сан хөмрөгөө нийтэд сурталчлах ажил хомс байснаас ном хэвлэлийг уншигч, олон нийтийн хүртээл болгох асуудал дутагдалтай байв. Мөн тэнд каталог, картын сан байтугай төсөв төлөвлөгөө ч үгүй, номын сангийн ажлыг зохион байгуулах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байсан юм.

БНМАУ-ын Соёлын яам эдгээр байдалд анхааран номын сангийн талаар бодлого боловсруулан УТНС-г голлох үүрэг гүйцэтгүүлэхээр онцлон заажээ.

Энэхүү хариуцлагатай үүргийг биелүүлэхийн тулд юуны өмнө номын сангийн урт, богино хугацааны семинар, курс зохион байгуулж, орон нутагт ажиллаж чадахуйц мэргэжлийн хүн хэрэгтэй тул 1962 оноос эхлэн 6 сарын курсыг 1965 он хүртэл 4 удаа явуулж, 300-аад хүнийг сургахад тэдэнд М.Баянзул болон бусад мэргэжилтнүүд хичээл зааж байжээ. Дараагийн жилүүдэд нь бүх аймгуудад мэргэжлийн номын санчид хуваарилагдаж сум, САА, дунд сургууль, техникумуудад номын санг шинээр байгуулах, үйлчилгээг хүргэх ажлыг эхлүүлэв. Мөн аймгууд өөр өөрсдийн орон нутагт богино хугацаагаар /2-3 долоо хоногоор, 1 сарын гэх мэт/ курс семинар байгуулж номын санчдыг сургаж байжээ.

Ийнхүү Улсын төв номын сангийн ажилтнууд өөрсдөө сурахын хамтаар алба нэгтнүүдээ сургах чиглэлээр ажилласан энэ хугацааг “ажиллангаа суралцах”, “суралцангаа сургах” он жилүүд байлаа.⁵ хэмээн Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Найдангийн Цагаач “*Монголын Үндэсний номын сан: Түүхэн бичлэг*” номондоо дурссан байдаг.

Монголын номын сангийн анхны үндэсний мэргэжилтнүүдийг бэлтгэх болон дээр дурьдсан “сургах, сурах” үйл явцад Магсарын Баянзул нь өөрийн боловсрол,

⁵ Н.Цагаач “Монголын Үндэсний номын сан: Түүхэн бичлэг”.- УБ., 2001.- Х.170.

мэдлэг чадвар, ухамсарт амьдралаа зориулсан манай тэргүүний сэхээтнүүдийн нэг байсан юм.

2. Бүтээн туурвисан мэргэжлийн ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээлүүд нь өнөөг хүртэл сургалт, судалгааны гол хэрэглэгдэхүүн гарын авлага болох нь

Магсарын Баянзул нь бие даасан бүтээл 20 гаруй, редакторлаж хянасан ном хэвлэл мөн 20 гаруйг, нийтлүүлсэн мэргэжлийн өгүүлэл 53, үүнээс номын санч сэтгүүл дээр 27, сурвалжлага тэмдэглэл 94, шүүмж 30 орчим, орчуулсан ном, өгүүллэг 7, гадаад орны сэтгүүлд материал 4-ийг нийтлүүлэн бичиж туурвижээ.

Эдгээрээс хэвлэгдсэн тухайн цаг үедээ маш чухал ач холбогдолтой, номын санчдын гарын авлага болж байсан зарим бүтээлийг нь:

- Мэргэжлийн ном бүтээл, гарын авлага;
- Номзүйн бүртгэл, лавлах хэвлэл;

гэсэн 2 чиглэлээр танилцуулья.

1. Мэргэжлийн ном бүтээл, гарын авлага;

1962 оноос орон нутагт байгуулагдсан номын сангуудад ажиллаж чадахуйц мэргэжлийн ажилтан бэлтгэх номын сангийн урт, богино хугацааны сургалт семинар, курс зохион байгуулж эхэлсэн энэ үед гарын авлага болох ном, сурах бичиг шаардлагатай болсон тул М.Баянзул нь Д.Сурмаажав, К.Н.Михайлов, Б.Цэдэндорж нарын хамт монголын номын сангуудад зориулан *“Номын сангийн аравтын ангилал”* хэмээх сурах бичиг боловсруулсан нь номоо дүрэм журмын дагуу ажиллагаанд оруулан каталог, картын санг бий болгоход чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Мөн энэ онд *“Номын сангийн арга ажиллагааны анхны мэдэгдэхүүн”* хэмээх номыг боловсруулан хэвлүүлжээ. Энэ номонд номын сангийн өдөр тутмын ажлын бүхий л арга ажиллагаа, аргачлал заавар орсон төдийгүй аливаа номын санд заавал хөтлөгддөг бүртгэл тооцоо, баримт бичгийн маягт загварыг хавсаргасан нь бүр ч их ач холбогдолтой байлаа.

Түүнчлэн М.Баянзул *“Номын фонд, түүнийг хамгаалахуй”* хэмээх сурах бичгийг 1968 онд хэвлүүлжээ. Энэ номд номын сан фондоо хэрхэн ямар арга

замаар бүрдүүлж, түүний бүртгэл тооцоог хэрхэн хөтлөх, номын сангийн номыг алдаж, үрэгдэх болон физик, хими, биологийн элдэв гэмтэл, галын аюулаас хэрхэн сэргийлэн хамгаалах тухай нарийн тодорхой зааж орон нутгийн бодит баримтаар баяжуулан бичсэн байна.

1974 онд М.Баянзул нь Ш.Базар, Л.Жамба нартай хамтран “*Номын сан судлал*” гэдэг ном боловсруулан хэвлүүлэв. Энд номын сангийн үйлчилгээ, аргазүйн ажил, фондын ашиглалт, зохион байгуулалт, номын засвар, сэлбэн засалт, тоног төхөөрөмж, номын сангийн өдөр тутмын ажлын норм, норматив зэрэг гол гол ажлуудыг багтаасан нь номын санчдын сонирхсон асуултад хариулт өгсөн чухал ач холбогдолтой ном болсон.

Энд бас нэгэн номыг дурьдахгүй өнгөрвөл ёс зүйгүй хэрэг болно.

1970, 1980-аад онд тус орны номын сангууд дэлхий дахины олон орны номын сангуудын нийтээр хэрэгжүүлж буй номын сангийн ангилалыг өөрийн орны номын сангуудад авч ашиглах шаардлага тулгарч иржээ. Энэ шаардлагаар “*Номын сан-номзүйн ангилал*” хэмээх 2 дахь гарын авлага, сурах бичгийг Ш.Базарын хамт өөрийн орны нөхцөл, түүхэн хөгжил, өвөрмөц байдлыг тусган нэмэлт оруулан боловсруулж, номын сангийн ангийн оюутнууд, номын санчдын суралцахад зориулан 1985 онд хэвлэн гаргасан нь 20 гаруй жил номын сангийн өдөр тутмын үйл ажиллагаа болон сургалтанд чухал гарын авлага болон хэрэглэгдэж байсан ба 2008 онд орчуулагдан хэвлэгдсэн, одоо хэрэглэгдэж байгаа “*Номын сан-номзүйн ангилал*” гэсэн шинэчилсэн гарын авлагыг боловсруулахад гол тулгуур нь болсон юм.

Энэ нь номын сангийн залуу боловсон хүчин В.Түвшинтогтохын “Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Магсарын Баянзулын номын сан судлалд оруулсан хувь нэмэр” гэсэн илтгэлд “*М.Баянзулын ном бүтээл, нийтлэлүүд өнөөдөр Монголын бүх төрлийн номын сангийн номын санчид, оюутан залуус, судлаачдын өдөр тутмын гарын авлага болж, иш татагдан хэрэглэгдсээр байгаа нь эдгээр бүтээл ямархан үнэ цэнэтэй болохыг илэрхийлж буй хэрэг юм.*”⁶ хэмээн дүгнэснийг батлаж байна.

Энэ мэтчилэн олон ном сурах бичиг, гарын авлагыг хэвлүүлснээс гадна мэргэжил нэгт нөхдийнхөө олон номыг хянан редакторлажээ.

Тухайлбал: Д.Данзан “*Лавлагаа-номзүй*”, Л.Жамба “*Номын сангийн ном сэлбэн засалт, тоноглол төхөөрөмж*”, В.В.Хурлат “*Номын сангийн хэвлэл тодорхойлох*

⁶ МУ-ын СГЗ Магсарын Баянзулын номын сан судлалд оруулсан хувь нэмэр: Илтгэл

гарын авлага”, Д.Цэрэнханд “Улсын нэр томъёоны комиссын мэдээ” /105-106-р/ Номын сангийн нэр томъёо, О.Цэндсүрэн “Хүүхдийн уншлагыг удирдах нь” гэх зэрэг номуудыг дурьдаж болох юм.

2. Номзүйн бүртгэл, лавлах хэвлэл;

Ерөнхий болон салбар, сэдэвчилсэн номзүйн бүртгэлүүдийг 1950-иад оны дунд үед улс орон даяар дэлгэрүүлж, түгээсэн гол хүч нь улсын төв номын санд ажиллаж байжээ. Эдгээр сэхээтний нэг нь М.Баянзул бөгөөд номын сангийн туршлагатай судлаач-номзүйч байсан юм. Түүний анхны бүтээл нь 1957 онд “1921-1955 онд монгол хэлэнд орчуулсан гадаад уран зохиолын номзүйн бүртгэл” нэртэйгээр хэвлэгджээ.

Түүнээс хойш мэдээлэл-номзүйн ажлыг тууштай оролдохоор шийдэж ЗХУ-д сургууль төгсөж ирээд монголын уран зохиолыг сурталчлах, нийт уншигчдад мэдээлэл өгөх ажлыг үргэлжлүүлсэн байна. Энд хамгийн түрүүнд “Монголын уран зохиолын номзүйн тойм” хэмээх 8 дэвтэр номзүйн бүртгэл нь том байр суурь эзэлнэ. Номзүйн энэ бүтээлд монголын 200 гаруй зохиолчийн нэрийг үсэг дарааллаар байрлуулан, бүтээлийг төрөл жанраар нь ангилан, хэвлэгдсэн оны дарааллаар оруулсаны дээр уул зохиолын талаар ямар шүүмж, судалгааны өгүүлэл хаана ямар хэвлэлд гарсан, мөн гадаадын аль улсын ямар хэвлэлд орчуулагдаж анх гарсан тухай мэдээлэл багтдаг юм.

Энэ бүтээлийн тухай Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн Н.Цагаач “Эрдмийн сувд” номондоо “Энэ бүтээл нь анх удаа мэргэжлийн номын санч номын сангийн мэргэжлийн шаардлагыг хангаж хийсэн иж бүрэн мэдээллийн аппарат бүхий сэдэвчилсэн судалгаа юм”⁷ гэж үнэлсэн байдаг.

Түүнчлэн “МХЗЭ-ийн номзүй 1921-1984”, “Нийгэм-улс төрийн номзүй” (1986), “1980-1984 онд хэвлэгдсэн монгол номын бүртгэл”, “ШУА-аас хэвлүүлсэн ном хэвлэлийн номзүйн бүртгэл” (1987), “Ленин, Ленинизмийн талаар хэвлэгдсэн ном өгүүллийн номзүйн бүртгэл” (1986) зэрэг мэдээлэл-номзүйн 20 гаруй бүтээлийг нэрлэж болно.

⁷ Н.Цагаач “Эрдмийн сувд”. – УБ., 2008. – Х.193.

М.Баянзул нь номзүйн бүртгэл өөрөө хийхээс гадна Д.Данзан, Л.Жамбаа, Д.Галсанпунцаг, Ш.Базар нарын 20 гаруй мэргэжилтний номзүйн бүртгэлийг редакторлаж, найруулан зассан нь үлэмж ач холбогдолтой бүтээлүүд болсон ба одоог хүртэл мэргэжлийн сургуулийн оюутнуудын гарын авлага болсоор байгаа төдийгүй бүх шинжлэх ухааны салбарын судлаачдын лавлах хэвлэл, хэрэглэгдэхүүн болсоор байгаа билээ.

Мөн номын сан судлалаар олон арван өгүүллийг өдөр тутмын сонин сэтгүүл, мэргэжлийн онол арга зүйн “Номын санч” сэтгүүлд нийтлүүлж байсан нь тухайн үеийн суралцагсдад чухал зөвлөмж, гарын авлага, материал болж байсан төдийгүй эдгээр нь мөн л өнөөг хүртэл хэрэглэгдэж байна.

Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, номын сангийн салбарын нэрт төлөөлөгч Магсарын Баянзул нь номын санд тасралтгүй 40-өөд жил ажиллахдаа номын сан, ном хэвлэлийн “Амьд нэвтэрхий толь” гэгдэж байсан ба энэхүү нэр алдрыг нь түүний бүтээж туурвисан олон ном, лавлах хэвлэлүүд нотлож, сургалт, судалгаа, лавлагаа номзүйн чухал гарын авлага болон тасралтгүй хэрэглэгдсээр ирлээ, цаашид ч хэрэглэгдсээр байх болно.

Монголын Хүүхдийн номын сангийн хөгжилд

Магсарын Баянзулын оруулсан хувь нэмэр

Хүүхдийн уран зохиолын номзүйд М.Баянзулын гүйцэтгэсэн үүрэг:

Цахим мэдээллийн ертөнц болох Google-ийн чөлөөт нэвтэрхий толь бичигт /“Википедиа”/ номзүйг (Библиография. Bibliography). Герегийн bibliography – “ном бүртгэх, бичих” гэсэн утгатай үгнээс гаралтай нэр томъёо болно. Номзүй шинжлэх ухаан, урлаг, утга зохиолын зэрэг мэдлэгийн олон салбараар гарсан ном, бүтээлүүдийг бүрдүүлэх замаар судалгааны томоохон эх сурвалж, мэдээллийн санг бий болгох, ном зохиолыг сурталчлах, олон түмэнд танин мэдүүлэх, шаардлагатай мэдээлэл олж авахад туслах, соёлын үнэт зүйлийг бүтээх зорилготой юм. Манайд зохиол, бүтээлийн номзүйг хийх талаар тодорхой туршлага бий болж, цөөнгүй бүтээл гарчээ. Жишээ нь: М.Баянзулын “Монголын уран зохиолын номзүйн тойм” (7 боть), Х.Сампилдэндэв, Д.Өлзийбаяр нарын “Монгол аман зохиол, уран зохиол судлалын номзүй” (1 боть), Л.Норовсүрэн, Г.Өнөрбаяр нарын “Монголын сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүдийн номзүйн лавламж” (1 боть) зэрэг бүтээлийг нэрлэж болно хэмээн оруулжээ. Үнэхээр Монголын номзүй , М.Баянзул гэдэг хоёр үг одоо болон ирээдүйд үргэлж хамт дуурсаж явах нь зайлшгүй юм. Учир нь Цахим ертөнцийн хамгийн шаардлагатай зүйл мэдээллийн сангийн өвөг дээдэс нь болох номзүй хэмээх шинжлэх ухааныг Монголд жинхэнэ утгаар нь мэргэжлийн түвшинд хийж уншигч, судлаачдад хүргэж байсан М.Баянзул гуайн гавьяа их юм.

М.Баянзул нь номын сан, номзүйн 30 гаруй бүтээл туурвисаны дотор “Монголын уран зохиолын номзүйн тойм” бүртгэлүүд нь 1921-1980-аад оны эхийг хамарч Монголын зохиолчдын бичиж туурвисан уран зохиолын бүх төрөл зүйлийг ном, тогтмол хэвлэлд нийтлэгдсэнээр нь ангилан тухай бүрийг нь товч агуулгаар тодорхойлон зохиолчдын намтар, тэдний уран бүтээлийн талаар гарсан шүүмжийн бүртгэлийг оруулж өгсөн нь цогц мэдээлэлтэй томоохон бүтээл болсон юм. Энэхүү бүртгэлүүдэд үе үеийн хүүхдийн уран зохиолын төлөөлөл болох Ч.Аръяасүрэн, Ж.Дашдондог, Д.Содномдорж, Н.Надмид, Ч.Лувсандэндэв зэрэг олон зохиолчдын бүтээл, түүнчлэн бусад зохиолчдын хүүхдэд зориулж бичсэн зохиол бүтээлүүд багтаж

чадсан нь цаашид хүүхдийн уран зохиолын талаар бие даан хэвлэгдэн гарсан номзүйн бүртгэлүүдийн үндэс болсон юм.

Тухайн үед Улсын Төв номын санд хэвлэгдэн гарсан бүх хэвлэлийн бүтээгдэхүүн бүрээс өгч архивлуулдаг байсан нь Үндэсний хэмжээний номзүйн бүртгэл үнэн зөв бодитой, бүрэн дүүрэн гарах эх болж мэргэжлийн номзүйчийн чадвар, няхуур хөдөлмөрч зан ч сайн номзүйн бүртгэл гарахад нөлөөлсөн гэж үзэж болно. Тухайлбал., Хүүхдийн номын ордноос эрхлэн гаргасан Хүүхдийн уран зохиолын номзүйн бүртгэл /1921-2012 оныг хамарсан/-ийг хийх явцад бидэнд М.Баянзулын “Монголын уран зохиолын номзүйн тойм” бүртгэлүүд бидний ширээний ном болж байсныг дурьдах нь зүй ёсны хэрэг юм. М.Баянзул “Монголын уран зохиолын номзүйн тойм” бүртгэлүүдэд хүүхдийн зохиолчдын намтар уран бүтээлийг оруулсан төдийгүй зарим зохиолуудын тухай товч дүгнэлтүүдийг бичсэн нь тухайн номзүйн бүртгэлийг хэрэглэгч хэн бүхэнд дөхөмтэй болгож өгчээ. Хүүхдийн уран зохиолын судлаач, шүүмжлэгч, доктор Д.Оюунбадрах /Sc.D/ “Монголын Хүүхдийн уран зохиол” номондоо дээрх бүртгэлүүдэд М.Баянзул хүүхдийн зохиолчдын зарим бүтээлүүдийг хэрхэн тусгаж өгсөн талаар оруулсан байдаг. Тухайлбал., МУЗНЗТ бүртгэлийн 4 дэвтэрт Ч.Уламбаярын бичсэн “Зовлон жаргал” зохиолын тухай энэхүү бүртгэлд “Романд тэмдгэлсэн гол дүр бол бяцхан хүү Дангаа бөгөөд зохиолч энэ дүрээрээ ардын хувьсгалчдын эгнээ өргөн тэлж буйг илтгэсэн ажээ” хэмээн товч тодорхойлолт хийснийг дурьджээ.

Хүүхдийн уран зохиолын номзүйн бүртгэлд томоохон суурь эзэлдэг бүртгэл бол 1969 онд Ч.Лувсандэндэвийн эрхлэн гаргасан “Хүүхдийн уран зохиол, ном хэвлэл” хэмээх гурван боть номзүйн бүртгэл юм. Энэхүү ботийн тухай Доктор /Sc.D/ Ж.Цэзэн “Багтаасан материалын цар хүрээ, төрөлжүүлэлт хийгээд зохиол тус бүрд хийсэн тодорхой тайлбар нь уншлагыг удирдахад багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, номын санчид төдийгүй сургуулийн насны хүүхдүүд уг лавлахыг ашиглах боломжтой болсон гэж үзэж болно” хэмээн дүгнэжээ. Энэхүү номзүйн бүртгэл мэргэжлийн түвшинд хийгдэж мэргэжилтнүүдээс өндөр үнэлгээ авдаг нь энэхүү номын редактороор нь М.Баянзул ажилласантай холбоотой хэмээн үзэж байна.

Мөн М.Баянзул нь Монголын Зохиолчдын Эвлэлийн гишүүний хувьд хүүхдийн зохиол бүтээлүүдэд цөөнгүй шүүмж бичиж байсан төдийгүй номын санчид, уншигчдыг төлөөлөн тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэж байсан. Түүний бичсэн шүүмж судлалд номзүйчийн мэргэжлийн онцлог тодхон харагдаж хэд хэдэн онуудад хэд

хичнээн ном гарч байсныг тодорхой дурьдаж цаашид ямар ном зохиол уншигчдад хэрэгцээ шаардлагатай байгааг дурьдаж байснаараа бусад шүүмжлэгчдээс ялгаатай байсныг харж болно. Жишээлэхэд., М.Баянзул “Дэлхий дахины уран зохиол Монголын уншигчдын дунд” шүүмж судлалдаа “Хэрэв 1921- 1945 онд Ази, Африкийн орны 50 шахам зохиолчийн бүтээл монгол нэрээр 100-аад мянган хувь хэвлүүлж байсан бол 1946-1960 онд 90 гаруй орны ном 1 сая шахам хувь хэвлэгдсэн байна. Одоо зөвхөн Ази Африкийн орны 100 гаруй зохиолчийн 500 шахам зохиолыг монгол уншигчид өөрийн хэлээр уншиж байгаагийн дээр 250-иад аман зохиолыг орчуулан хэвлэжээ”.

Мөн энэхүү шүүмж зохиолоос харахад манай улсын орчуулгын зохиолд Дорно дахины зохиолууд том байр суурь эзэлж байсныг “Бүр 13-14-р зууны үеэс Монголчууд айл зэргэлдээ Азийн улс үндэстний хэлээс ном зохиол орчуулж байсан тухай сурвалж бичиг, эрдэмтдийн судалгаа тэмдэглэлд өдий төдий баримт үлдээжээ. Эртний соёлын өв уламжлалтай Монголчуудын эрдэм ном сурах авъяас, дуулж хуурдах дур сонирхол нь бусад үндэстэний соёлын эрдэнэстэй танилцаж өөрийн үндэстний утга зохиолыг хөгжүүлэхэд нөлөө түлхэц болсон нь дамжиггүй” гэж тэмдгэлсэн байна. Харин Өрнө дахины уран зохиолын орчуулга нь харьцангуй хойно 1930-аад оны үеэс хүүхдэд зориулсан орчуулгын зохиолуудаар эхэлж байсныг ийнхүү тодорхойлжээ. “Орчуулгын эхний үед Оросын болон Өрнө дахины ардын үлгэрүүд, Пушкин, Лермонтов, Некрасовын шүлгүүд, Крыловын ёгт үлгэрүүд, Салтыков Щедрин, Л.Тольстой, Горький, Чехов нарын үлгэр өгүүллэгүүдээр эхэлж улмаар тэдний шилдэг том бүтээлүүд болон өрнө дахины сонгодог зохиолуудаас орчуулж байлаа” хэмээн дурьдсан байна.

Хүүхдийн номын сангийн ангилал

Олон улсын хүүхдийн жил болох 1979 онд хүүхдийн төлөө фондын дарга А.И.Цэдэнбал Филатовагийн санаачилгаар хуучин Болгарын элчин сайдын яам байсан 2 давхар байранд Хүүхдийн номын сан байгуулсан байна. Хүүхдийн номын санг байгуулахад Улсын Нийтийн номын сан фонд бүрдүүлэх, мэргэжлийн арга зүйн зөвлөгөө өгөх зэргээр ихээхэн үүрэгтэй ажилласан төдийгүй хүүхдийн номын санд зориулсан ангилалыг шинээр хэвлүүлсэн байна. М.Баянзул нийтийн номын сангуудад зориулсан ангилал боловсруулж байсан туршлага дээрээ үндэслэн ЗХУ-ын Лениний нэрэмжит номын сан, М.Е.Салтыков Щедриний нэрэмжит Нийтийн номын сан, ЗХУ-ын

ШУА-ийн номын сан, Бүх Холбоотын улсын номын танхим, ЗСБНХУ-ын Хүүхдийн Төв номын сангаас хамтран боловсруулсан “Номын сан-номзүйн ангилал ном”-ыг Н.Цагаачийн хамт орчуулан, өөрийн орны номын сангуудын онцлогт тохируулан боловсруулж хэвлүүлсэн байна.

Энэ ангилал нь хүүхдийн ба сургуулийн номын сангууд номоо шинжлэх ухааны үндэстэйгээр ангилж, номын сангийн үйл ажиллагаанд оруулах, каталог картын сан зохион байгуулах, фонд бүрдүүлэх гээд номын сангийн бүхий л үйл ажиллагаандаа ашигладаг гарын авлага болж байжээ.

Ном зүй:

- Баянзул М. Монголын уран зохиолын номзүйн тойм: 4 дэвт.- УБ.: УХГ., 1966.
- Базар Ш. Номын заяатай хүн.- УБ.: 2010.- 97х.
- Оюунбадрах Д. Монголын хүүхдийн уран зохиолын номзүйн тойм: 3 дэвт.- УБ.: 2010.- 258 х.
- Монголын уран зохиолын судлал, шүүмж.- УБ.: УХГ., 1982.- Х. 27-33.
- Номын сан ном зүйн ангилал / Боловср. М.Баянзул., Н.Цагаач.
- Цагаач Н. Монголын Үндэсний номын сан.- УБ.: УХГ., 2008.- 352 х.
- Цагаач Н. Эрдмийн сувд.- УБ.: 2008.- 352 х.
- Google

*Данзанноровын Хүү /МУБИС-ийн профессор,
утга зохиолын судлаач, шүүмжлэгч/*

**МУСГЗүтгэлтэн М.Баянзулын бүтээл дэх
шүүмж, судалгааны бүтээлийн онцлог**

/Мэндэлсний нь 85 насны ойд/

Ном унших, номын санд суух бол 1970-аад оны “Оюутны байр”-ны надад үндсэн ажил болж, эрдэм ухаарлаа ундраах энергийн төв “Гэр минь” УННС байсныг дурсахад л М.Баянзул гуайн тухай яриа эхэлж, түүний бүтээлээс цуглуулснаа нэрлэхээс аргагүйд хүрдэг юм. Номын сангийн удирдах ажилтан М.Баянзул гавъяатын бүтээлийг ярилцах, эсвэл нэрлэх нь том хүндэтгэл тул, танд тэдгээр бүтээлийн нь бүрэн агуулгыг тодруулсан цөөн “Шүүмж”-ийг нэрлэе.

1. Баянзул М. Уран зохиолын чанарын тухай // УЗУ сонин.- 1956.08.15.- № 16\26
2. Баянзул М. “Тунгалаг тамир” ямар санагдана вэ? // Цог.- 1963.- №1.- Х.110.
3. Баянзул М. Хүүхдийн 2 номын тухай // Цог.- 1965.- №2.- Х.112.
4. Баянзул М. Д.Нацагдоржийн нийтлэгдээгүй гурван шүлэг // Утга зохиол, урлаг.- 1966.- № 31.
5. Баянзул М. Нацагдоржийн зохиол гадаад хэлээр // УЗУ.- 1966.- № 46.
6. Баянзул М. Ширбазарын Содномдорж // УЗУ.- 1967.- № 2.
7. Баянзул М. М.В.Булышев // УЗУ.- 1967.- № 17.
8. Баянзул М. Шастиныхан // УЗУ.- 1967.- № 42.
9. Баянзул М. Орос зөвлөлтийн зохиолоос орчуулж эхэлсэн нь // УЗУ.- 1967.10.27.- №44.565
10. Баянзул М. Горький ба хүүхдийн утга зохиол // Сурган хүмүүжүүлэгч.- 1968.- №2.
11. Баянзул М. Горький хүүхдийн утга зохиолын тухай // Залуучуудын үнэн.- 1977.- №17.
12. Баянзул М. М.Горькийн зохиол Монгол хэл дээр (100 жилд) // Хөдөлмөр.- 1968.- №20.
13. Баянзул М. М.Горькийн зохиол Монголд // Цог.- 1968.- №2.
14. Баянзул М. Томас Майн Рид // УЗУ.- 1968.- №16.

15. Баянзул М. “Зам” Ямар байна // Цог.- 1968.- №4.- 145-155 тал.
16. Баянзул М. Сүүлийн үеийн туужуудын тухай // УЗУ.- 1970.03.27.- №13 (704)
17. Баянзул М. Анхны шүлэглэлээс роман хүртэл // УЗУ.- 1970.10.31.- №42 (733)
18. Баянзул М. Ардын намын тухай анхны шүлэглэлийн тэмдэглэл // Залуучуудын Үнэн.- 1971.- №18.
19. Баянзул М. Сүүлийн үеийн туужийн тухай // Цог.- 1971.- №4.- Х.133.
20. Баянзул М. “Сугаавадын орноор” сурвалжилбал // Үнэн.- 1973.- №293.
21. Баянзул М. Үүрээр боссон баатрууд // Үнэн.- 1971.- №93.
22. Баянзул М. Хөгжлийн асуудлыг хөндсөн бүтээл // УЗУ.- 1971.- №49.
23. Баянзул М. Эхлэн бичигчдийн зарим зохиолын тухай // УЗУ.- 1973.- №49.
24. Баянзул М. М.Горький, Хүүхдийн утга зохиолын тухай // Залуучуудын үнэн.- 1977.- №17...

Эдгээрээс уншихад л хорин дөрөвдөхгүй. Монголын орчин цагийн уран зохиолын хөгжилт, түүний гадаад, дотоод нөлөөлөл, зохиогчийн өмнөх ба тухайн үед байсан зохиолчдын төлөөлөгчдийг ч хамтатгасан үнэлэмж болдгоороо онцлог байгаа юм. Тиймээс шүүмж төдийхнөөр хязгаарлагддаг явцуу, хүрээгээр бодож М.Баянзул гуайг ярьж болохгүй гэдэг нь ч бас эдгээрээс харагдах биз.

Оюутны анхны хичээл эхлээд сар болоогүй 1969 оны 10 сард сан миний бие “Ганжуур, Данжуур”-ыг уншлагын танхимд захиалгад бичээд явуултал, нийтийн уншлагад гаргадаггүйг тайлбарлаад, намайг оюутан гэж голж, чамлалгүй дагуулан явж, ЭШ-ний уншлагын танхимд суулгасан тохиолдлоос би номзүйч, судлаач М.Баянзул гуайг аргагүй л номын танхим дотор нь орж байж мэддэг болсон юм.

Дараа нь тэр хүний зөвлөснөөр УБДС-ийн Эрдмийн зөвлөлөөс хүсэлт гаргуулж, УННС-тай холбогдож, Эрдэм шинжилгээний ажилтны уншлагын танхимд сууж, ажиллах эрхийн пиубичиг нээлгэсэн ганцхан оюутан гэгдэв. Оюутны хүрээнээс давуулж уншсанаар эрдэмтдийн индэр болж, байсан Шинжлэх ухаан амьдрал сэтгүүлд “Овог”, “Билгийн улирлын тоолол /2050 он хүртэл тоололтой/” нэртэй үгүүллүүдээ хэвлүүлж амжсан минь бараг 45 жилийн өмнөх явдал.

Уншигчийн тэр үнэмлэхээрээ УННС-д орж гарсаар миний бие шат, шатны боловсролтон болоод өдгөө 45 дахь жилээ угтаж байна. “Багш хүүхэд” гэж М.Баянзул гуай надад “Хайрласан” гэгээн нэрийг сэвтүүлэлгүй ажиллаж бас л 45 жилрүү өнгийж яваа билээ. Чамайг Багшийн багш болсныг “бүтээлүүд чинь хэлсэн”, соёлын салбартай, хөгжмийн ангитай, бас **номын санч** бэлтгэж байсан **1945** онд гэж төгссөн

тоог оруулан, би Ховдын Мянгад сумаас ирж 18-тайдаа танай сургуульд суралцаж төгссөн юм гэж 1961 онд Москвад “Соёлын дээд сургуулийг дүүргэж, номзүйч болсныхоо өмнөх үе болох, **“1945-он, Багшийн сургууль, соёлын салбар”-аа** л гэдэг байсан нь... Ийм учиртай аж.

М.Баянзул гуайг дурссан, дурсамждаа бичсэн миний тоонууд ч бас л адилхан дурсах “дөчин тав”-уудтай үе тохиов. Тэртээх 1922 онд Багшийн сургууль, Улсын номын сан хоёул үүсэн байгуулагджээ. Харин М.Баянзул гуайн амьдрал эдгээртэй холбогдсон нь түүний 85-ны нас, сүүдэр зэрэгцсэнийг тэмдэглэхэд, тэртээх 1945 оных нь дурсамжийн байгууллагууд хамтрагчид нь байсанд сэтгэл хөдлөв.

М.Баянзул нутагтаа багшилж, улмаар 1950 оноос УННС-д ирж, ажилласнаа дурссаныг сонссон тэрхэн хормоос хойш мөнхүү 45 он улирах бололтой. М.Баянзул гуай уншлагын талбарт бол “Багш хүүхэд” гэж намайг нэрлэнэ. Учир нь эхний ажилтантай нь уралдаж ороод, уншлага хаах “22 цагт хөөгдөж” гардаг хэдэн оюутныг андахгүй болж, захиалгын хуудсаар нь л гадарладгаас тэр юм.

Тэд бол одоогийн академич зурхайч Л.Тэрбиш, хүний гавьяат эмч ах, дүү Т.Шагдарсүрэн, Т.Сандуйжав бид л дээ. Тус тусын сургуулиа төгсгөөд мөн л 45 жил болох нь ээ. М.Баянзул гуай 1971 оны хаврын нэг өдөр миний хажуугийн ширээнд зэрэгцээ ирж, уншигчтай ярилцахдаа шинэ номын тухай бололтой “Үүрээр боссон баатар”-уудыг хэвлэлд өгсөн гэв. Дөнгөж уншлагад очоод байсан туульсын найраглал /Д.Даржаа/-ын нэр сонсогдоход түүний шүүмж гэдгийг гадарлан харвал зохиолч ярилцагч нь П.Хорлоо гуай байлаа. Хожим нь академич П.Хорлоо багштан миний эрдмийн сэдвийн удирдагч болох юм гэж тэрхэн мөчид, мэдэлгүй хоцорсноо холбон дурсмаараа. Харин тэдний яриаг нь дараа өдрийн “Үнэн” /1971.- №93/ сониноос тосч уншсан билээ.

М.Баянзулын “Уран зохиолын чанарын тухай (УЗУ. 1956.- №16/26)”, “Тунгалаг тамир, ямар санагдана вэ? (Цог. 1963.- №1.1109)”, “Хүүхдийн 2 номын тухай (Цог. 1965.- №2.112)” зэрэг бүтээлүүд бол 1960-аад оных буюу түүний шүүмж, судалгааны бүтээлийнх нь эхлэл ч гэгддэг бол, Монголын шинэ үеийн уран зохиолын номзүйн тойм (1965-80)-ын 7 боть ном нь чиглэлдээ бас анхдагч юм.

Утга зохиолын судлалд “Зохиолчдын амлалт, биелэлт” шаарддаг бичлэгийн хэлбэрийг М.Баянзул ашигласнаар (УЗУ. 1956.08.15. №16) тухайн цагтаа аман төлөвлөгөө төдий асан “Тунгалаг тамир (Ч.Л)”, “Хавар, Намар (Ч.Ч)” зэрэг шилдэг роман, бас бус олон зохиол буй болсон байдаг. М.Баянзул “Улс орны хөгжлийн нүүр

царай, түүний дотоод мөн чанарыг уран сайхны аргаар илтгэн харуулах баримт бол, орчин үеийн уран зохиол” гэдгийг хэлж “Хөгжлийн асуудлыг хөндсөн бүтээл. (Утга зохиол, урлаг сонин. 1971.- №49)” гэдэг тайлбартаа ч тодорхой дүгнэсэн нь бий.

Шинэ мэдээ, тайлбар сайтай шүүмжүүддээ “Соёлын зам”, “Уран зохиолын цомирлог”, “Залуу Максим Горькийчүүд болцгооё” зэрэг анхны сонин сэтгүүлүүд, нэн ховордсон хуучин номонд хэвлэгдсэн соёлын тухай материал, сонин содон санааг олж оролцуулдгаас М.Баянзулын бичлэг уншууртай гэгдэж байлаа. Харин 1955 оны 8-р сарын 1-ээс “Утга зохиол, урлаг” сонин гарах болсныг, бас “Цог” сэтгүүлийг дүгнэсэн сэтгэгдэлдээ “Зохиолыг чиг зүгтэй байлгаж, ноён нуруу алдуулаагүй...” талаас нь тусгайлан анхаарсан байх аж.

Судлаач шүүмжлэгч Г.Жамсранжав, Ц.Хасбаатар, С.Лувсанвандан, Д.Цэнд, Ц.Мөнх, Г.Ринчэнсамбуу нарыг бүтээлдээ эшилдэг, уншдаг нэгэн байсан нь М.Баянзулын бүтээлээс ажиглагдана. Д.Нацагдоржийн гурван шүлгийг шинээр олж, “Утга зохиол, урлаг. (1966 №31)” сонинд хэвлүүлэхдээ “5 минутын уралдааны шүлгүүд байж болох”-ыг тодотгосон мета удиртгал нь Нацагдорж судлалд оруулсан шинэ мэдээ болсныг тэмдэглэе.

Тэр шүлэгт нь : “...өвгөн шувуу гав ганцаар суухад

өндөр хад чив чимээгүй ажиглана.

Өвлийн хатуу салхи нь үлээхэд

Өлөн чоно ганцаар түүнийг тойрно...” (УЗУ. 1966.- №31) гэж байдаг аж. М.Баянзул нь МАРЗ-ын товчоонд сонгогдон улмаар “Хувьсгалт уран зохиолын түүх, байдлын тухай. 1930” гэх илтгэл хэлэлцүүлж, МАРЗ-ыг нийтэд зарлах, болон түүний бүтэц байгуулалтын төлөвлөгөөний эхийг боловсруулахад Д.Нацагдоржтой хамт ажилласан М.В.Булышевыг уншигчдад мэдээлж чадсан судлаач байв.

Зохиолын чанарыг

- Нийгэм, цаг үе
- Урлах арга, барилын өсөлт
- Сэдэв, агуулга, хэлбэрийн нэгдэл
- Дүр, дүрслэл, зохиомж бүтэц, төрөл зүйл
- Ном шүүмжлэгдэх нь, зохиолчийн боловсруулалт
- Аман баримт, уран зөгнөл, үлгэрлэг бичлэг

- Редактор бол, зохиолыг шийдвэрлэлцэх эзний нэг юм гэдэг талаас нь ажиглалт хийж, “Утга зохиолын хөгжлийн асуудлууд. УБ. 1971” нэртэй цуврал шүүмж судалгааны тайлан, шилмэл бүтээлийн эмхтгэлүүдийн талаар тойм үгүүлэл олныг бичжээ. Улмаар шүүмж судлалын салбарыг дагнан авч, тэр чиглэлийн бүтээлийг зүйлчлэн тоймлож “1930 оноос С.Буннэмэх, Ч.Дашням нар эхний бүтээлүүд бичсэн байна” гэж үзсэн байна.

Зохиолын шүүмжлэлдээ, баримтат /Тайлан, түүхэн, тойм/, уран сайхны /Хоосон, бэлгэдэлт. (Цог 1971 №4.135)/- гэгддэг уламжлалт хэмжээг харгалздаг нь, “Сарны доорхи хорвоо (Ш.Сүрэнжав)”, “Хилийн чулуу (А.Дандий-Ядам)”, “Эргэлзээ (Дуг.Дорж)” зэрэгт бичсэн шүүмжид нь тусч байгаа бол, ихэрлэсэн, дуураймал бичлэг зохиолд байгааг, “Хойт эх (Ц.Уламбаяр)”, “Халагдсан цэрэг (Д.Мягмар)”, “Цөн түрсэн нь (Б.Бааст)”, “Үүрийн туяа (Б.Ринчен)”, “Зам ямар байна (Н.Банзрагч)” зэрэг том, жижиг зохиолуудад бичсэн шүүмжээс нь хэсэглэн ажиглах боломж байна.

Зохиолын тайлбар, нөлөөлөл, бүртгэл, хялбаршууллын талыг цуврал зохиомжоор холбосон хэд хэдэн бүтээлүүддээ илэрхийлж, Монгол зохиолыг пролетарийн урлагын төлөөлөгч М.Горькийтэй холбогчдод, шүүмжлэлтэй хандаж байжээ. Тэр ч бүү хэл “Өсвөрийн Сүхбаатарчууд /Юные Сухэбаторцы/” гэдэг номын шүүмжээ /Зал.үнэн. 1978.- №15/ нийтлэлд л байж болмоор уншигчийн нас биений онцлог ялгарах үг хэлээр найруулсан байв. Зохиол дотроос “...үл ажиглагдам жирийн атлаа, нарийн ширийн зүйлээс нь, учир зүйн эрэл хайгуул хийж, эрдэнэ сувдыг нь тунгааж, олж хэлдэг...” чадвар М.Баянзулд байгааг “(Сугаавадын орноор сурвалжилбал. Үнэн. 1973.- №93)” гэдэг сэтгэгдэл шүүмжээс нь олж, бусдын уран бүтээлд уншигч яаж хандах, түүнийг бүтээхийн талын зам бэрхшээлийг ч зэрэгцүүлэн мэдэж авахаар бичжээ.

Энэ мэт голлох шүүмжүүдэд нь задаргаа хийвэл, сонгосон зохиолоо эргэцүүлж, баримтаар дүгнэдэг шүүмжлээчийн хандлага, зохиолчийн санааг өлгөж тайлбар хийх ур ухаарлын гаргалгаа, зохиогчоо хайрласан сэтгэл, үзэл бодлын гэгддэг олон ургалч дүрслэлтэй ажилладаг хувийн арга туршлага нь тодорч, тэдгээрийг нь жишээгээр холбон тайлбарлавал, М.Баянзулаас суралцагчид олширч, утга зохиолын энэ салбарт ажиллах хожмын залуус, бас судлаачдад ч давхар хэрэг болох юм.

Эшлэл элбэгтэй. Тиймээс В.Г.Белинский, Н.А.Добролюбов, А.С.Макаренко нар ч М.Баянзулын шүүмжид оролцох аж. Үүхдээс гадна хүүхдийн “Нэг голынхон. НБ”, “Малчны жаалууд. ГС” /Цог. 1965.- №2.112/ номуудын дутагдлыг зохиолчийн талаас гаргаж, сэтгэл хөдлөлөө шахсан, бас гадаад төрхөөр түрсэн төдий оруулбар ихтэйгээрээ, хүүхдийн гэмээргүй харин үг, хэллэгийн ургүй хэлхээс мэт өнгөц бичлэгтэйг илчилж байжээ.

М.Баянзул “УЗ-ын чанарын тухай (УЗУ сонин. 1956.8.15 № 16/26)” үгүүлэлдээ, үгээр зурах, найруулахад олсон зохиолчдын амжилтыг хүүрнэл зохиол дээр ажиглаж, түүнийгээ “Сүүлийн үеийн туужийн тухай тэмдэглэл” (Цог. 1971.- №4.133) нэрээр хэвлүүлж, улмаар “1960-аад он” бол үгийн урлагын салбарт “өндөр ургац”-ын жилүүд гэжээ. Утга зохиолын тухайд хийсэн М.Баянзулын дүгнэлтүүдэд цаана нь соёлын асуудал дагалдах бөгөөд, онцлогоор нь тайлбар ч гэхэд болно.

Хэлбэрийн талаасаа эмзэг гэгддэг бичлэг бол захидал шүүмж юм. Судлаач М.Баянзулын бичиж үлдээсэн захидлууд дотроос “Эхлэн бичигчдийн зарим зохиолын тухай (УЗУ. 1973.- №49)”-гаар нэрлэсэн нэг захидлыг сөхье. Захидалд нэрлүүлсэн “хөдөөх залуус” өдгөө ахмад зохиолчид гэгдэж, харин эхлэн бичигч явсан, оюутан Ц.Цэрэндорж л гэхэд Монгол улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цолтон болоод байгаа аж.

“Хувьсгалт соёлын чухал хэсэг болсон шинэ уран зохиол” (Анхны шүлэглэлээс Роман хүртэл. 1970)-оо М.Баянзул гуай л анхлан 1921 оноос эхлүүлэн бүртгэн багцаалж, судалгаандаа тоймлон оруулж, түүнийг “Номзүйн” олон товхимол болгож эмхэтгэн нийтлүүлж эрдэмтэн нөхдийнхөө нэгэн адилаар бичиж үлдээснээс гадна өөрийн зохиол бүтээлээ дээр нь нэмэрлэж, бас орчуулж баяжуулсаар явсан хөдөлмөрч хүн байлаа.